MMINFO.
18 дахь жилдээ
# МОНГОЛЫН МЭДЭЭ
Хүн ам 3,101.455.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.08.25. Пүрэв. №149 (4519) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

БНСУ-ЫН ЭЛЧИН САЙД МОНГОЛ ДАЛАЙЧДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨР НЭМЭГДЭХГҮЙ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Ухаалаг системд шилжсэнээ мартаад байна уу даа

Ч.ЧУЛУУН

Ухаалаг системдээ итгэхгүй байх аваас түүнийг ашиглахын хэрэг байна уу хэмээн Замын цагдаагийн нөхдүүдээс асуумаар байна. Монгол Улсын нийслэл төдийгүй 21 аймаг цахим сүлжээнд холбогдсоноор тухайн иргэний бичиг баримттай холбоотой бүхий л асуудал эрх бүхий албан тушаалтны компьютерт удам судар, албан тушаал, өмч хөрөнгө, гэрийн хаягтайгаа хадгалагдаж буй. Энэхүү мэдээллийн санг хамгийн ихээр, өдөр тутам ашигладаг газруудын нэг нь аймаг, нийслэлийн Замын цагдаагийн хэлтэс, тасгууд. Гэвч замын цагдаа нар тэрхүү цахим сүлжээнд хадгалагдсан мэдээлэлд итгэдэггүй, жолооны цахим үнэмлэхийг зөвхөн өөрсдийн нүдээр харж, хуруунуухаа өндгөөр мэдэрч гэмээнэ сааа нь амардаг болохыг юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# АРДЫН НАМ АРД ТҮМЭНДЭЭ ТОМООС ТОМ “САЛААВЧ” ӨГЛӨӨ




Б.ӨНӨРТОГТОХ

Магтсан хүүхэн хуримандаа унгана гэгчээр Монгол Улсаа “МАН”-дуулж, аз жаргалтай хотод амьдруулах тухай үлгэр ярьсаар гарч ирсэн МАН-ын Засгийн газар эхний шалгалтад бүдэрлээ. МАН бол зүүний чиглэлтэй нам. Тэр ч утгаараа бүтээн байгуулалт гэхээс илүүтэй халамжийг гол чиглэл болгож ажилладаг. Өнгөрсөн дөрвөн жилд улс оронд том том бүтээн байгуулалт хийгдэж, үйлдвэрлэл хөгжсөн ч иргэдийн гарт очдог бэлэн мөнгө зарим талаараа хасагдсан учраас халамжаа санасан иргэд хуучин сонголтоо хийсэн гэдгийг олон талын судалгаа харуулдаг юм билээ. Өөрөөр хэлбэл, ард түмэн хэтэрхий богино ой санамжтай. Тэдэнд маргаашийн сайхан амьдрал бус өнөөдрийн бэлэн мөнгө л чухал учраас МАН-ын хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт хууртаж, тус намаас нэр дэвшсэн “бор халзан хонийг” хүртэл ялуулж байлаа. Шуудхан хэлэхэд, 20 жил халамжлуулснаа л санагалзаж МАН-ыг дэмжсэн. Гэвч монголчууд хууртчихаж. Эхчүүд, хүүхдүүдэд их хэмжээний мөнгө тарааж, оюутан нэг бүрийг тансаглуулах тухай үлгэрт нь итгэж байснаа тэд хоёрхон сарын дараа ойлгож байна. Энэ намын төлөө санал өгсөн ахмадууд тэтгэврийн зээлийн хүүг маань бууруулж, тэтгэврт гарах насыг урагшлуулчих болов уу хэмээн итгэж байсан биз. Дөрвөөс дээш хүүхэдтэй гэр бүлийг орон сууцжуулах тухай сайхан яриандь нь ямар олон гэр бүл хууртсан бол. Эхчүүдийн халамжийн мөнгийг нэмэх, хүүхдийн мөнгийг үе шаттай нэмэгдүүлэх тухай амлалтад олон ч ээжүүд хууртсанаа хэтэрхий хожимдож ойлгож байна. Улсын төсөв хоосорч, улс орон дампуурсан тухай сүржин мэдэгдэл хийснийхээ дараа тэд “МАН”-дуулах мөрийн хөтөлбөртөө тусгасан бүх зүйл заалтынхаа эсрэг ажил хийхээр болсноо зарлав.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# П.ЦАГААН АН-ЫН ШИНЭЧЛЭЛИЙН МАРАФОНД “ГҮЙХ”-ЭЭ МЭДЭГДЛЭЭ

Ж.ОТГОН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд хэвлэлийн бага хурал зарлалаа. Хурлын үеэр тэрбээр хэлсэн үгэндээ “Миний бие 2009 оноос хойш өнөөг хүртэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн Дэд бүтэц, эрдэс баялаг, Хуулийн зөвлөх, Цэрэг, Аюулгүй байдлын зөвлөх, ахлах зөвлөх, Тамгын газрын дарга ажиллаж, Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад, дотоод бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад бүхий л хүч чадлаа зорилуулан ажиллаж ирлээ. ЭдүгээЕрөнхийлөгчийнТамгын газар хамгийн тогтвортой, тасралтгүй, гацаагүй, хүнд сурталгүй үйл ажиллагаатай институци болж төлөвшсөн. Чадварлаг залуу хамт олноос бүрдэж байгаа. Цаашид ч энэ эрч хүчээрээ ажиллана гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Энэ жил гэхэд л үндэсний түүх, соёлтой холбоотой арга хэмжээ болон АСЕМ, Олон улсын монголч эрдэмтний их хурал гээд олон ажлыг амжилттай зохион байгуулсныг та бүхэн сайн мэдэж байгаа” гэлээ.

Тэрбээр энэ удаад Ерөнхийлөгчийн болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хийсэнгүй.

**Үргэлжлэл нь II нүүрт**




ЧУХАЛ СЭДЭВ

# Б.Мөнхзаяа: Ипотекийн зээлийг хязгаарлахгүй бол эдийн засгийн эргэлт зогсчихлоо



Н.ПУНЦАГБОЛД

*Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгч, эдийн засагч, доктор Б.Мөнхзаяаг “Чухал сэдэв” буландаа урьж, Монголын эдийн засгийн болоод банкны салбарын өнөөгийн байдлын талаар ярилцлаа. Тэрбээр өнгөрсөн даваа гарагт болсон “Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, хүндрэл, гарц, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, “Банкны секторын нөхцөл байдал” сэдвээр илтгэл тавьсан билээ.*

**-Монголын өмнөө барих эдийн засагчид нэг дор цугларч, эдийн засгийн нөхцөл байдал, гарц, шийдлийн талаар хэлэлцлээ. Энэ хэлэлцүүлгээс ямар үр дүн гарна гэж харж байна вэ?**

-Аливаа шийдвэрийг гаргахад асуудлыг олон талаас нь харж байж шийдэл хүрэх хэрэгтэй л дээ. Түйлын зөв ганц гарц гэж байхгүй учраас тэр. Тийм болохоор эдийн засагчид өөр өөрийнхөө байр суурийг хэлэх хэрэгтэй. Харин бодлого боловсруулж байгаа хүмүүс нь нэг шийдэл олж хараад, шийдвэр гаргахдаа тусгах хэрэгтэй байх гэж харж байна. Энэ хэлэлцүүлгийн үеэр гарч байгаа судлаачдын санаа бодлыг өөрсдийнхөө шийдлийн нэг хэсэг болгосой гэж хүсч байгаа юм. Өмнө нь 2008 оны санхүүгийн хямралын дараа ч гэсэн олон судлаачид, эдийн засагчдын цуглуулаад, янз бүрийн хэлэлцүүлэг өрнүүлж байсан. Харамсалтай нь эдийн засагчид, судлаачдын гаргасан санаа төрийн ажил хэрэгт огт тусдаггүй. Тийм болохоор эдийн засагчид чинь “Бид энд ингэж цуглаж, ярих хэрэг байна уу. Тэртэй тэргүй бидний саналыг тусгаж авдаггүй шүү дээ” гэж цөхөрч байна.

**Үргэлжлэл нь IV нүүрт**



| | ХААН банк | | | | | Худалдаа хөгжлийн банк | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2250.00 | 2273.00 | ФУНТ | 2925.00 | 3025.00 | АМ.ДОЛЛАР | 2250.00 | 2273.00 | ФУНТ | 2934.00 | 3032.00 |
| ЕВРО | 2520.00 | 2588.00 | РУБЛЬ | 32.80 | 36.70 | ЕВРО | 2517.00 | 2603.00 | РУБЛЬ | 33.68 | 36.85 |
| ИЕН | 22.21 | 22.86 | ЮАНЬ | 336.00 | 345.90 | ИЕН | 22.15 | 23.00 | ЮАНЬ | 336.30 | 345.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## О.Баасанхүү: Миний хүүхдүүд юу идэж амьдрах юм

УИХ-ын гишүүн О.Баасанхүү төсвийн тодотголтой холбоотой асуудлаар Төрийн ордонд мэдээлэл хийлээ. Тэрбээр “Төсөвт тодотгол хийх тогтоолын төсөлтэй танилцлаа. Санал нийлэхгүй асуудал нэлээд байна. Манай МАХН-ын мөрийн хөтөлбөртэй ч уялдахгүй байна. Тиймээс энэ тодотголыг дэмжихгүй гэдгээ илэрхийлэх гэсэн юм. Төрийн өмчийн компанийн захирлууд нэлээд их цалин авдаг юм шиг байна лээ. Тиймээс тийм хэмжээний цалинг хасах нь зөв. Гэхдээ төрд ажиллаж байгаа хэн ч гэсэн цалингаа хасуулах дургүй л дээ. Би нэг сая 200 мянган төгрөгийн цалин авч амьдралаа залгуулдаг. Энэ цалингаа хасуулчихвал миний хүүхдүүд юу идэж амьдрах юм. Цалин бол тэр хүний амьжиргааны эх үүсвэр юм” гэлээ. Тиймээс нэг аймагт зургаан ширхэг соёлын төв барих үрэлгэн зардлыг танамаар байна гэв. Мөн дэд сайд хөтөлбөрийг болиулах хэрэгтэй. Дэд сайдын туслах, жолооч зөвлөх, томилолтын зардал гэх мэт маш олон зарлага гарна. Тиймээс дэд сайдуудаа татаад авчих хэрэгтэйг сануууллаа. Түүнчлэн хувь хүний орлогын албан татварыг тэр дундаа эгэл жирийн бизнес хийдэг хүмүүсийн татварыг нэмж байгаа нь буруу. Уг нь МАН өмнө нь татвар нэмэхийг эсэргүүцэж байсан. Тэгж ярьж байсан хүмүүсийн 20 нь одоогийн парламентад байдаг. Ер нь МАН-ын ашиг сонирхлын зөрчилтэй нөхөд гарч ирээд сонгуульд зарцуулсан зардлаа нөхөх гэж байгаа мэт ийм ажил хийвэл бүтэхгүй хэмээлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**




# П.ЦАГААН АН-ЫН ШИНЭЧЛЭЛИЙН МАРАФОНД “ГҮЙХ”-ЭЭ МЭДЭГДЛЭЭ

Харин өөрийн гаргасан улстөрийн шийдвэрийн талаар мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Өнөөдөр Монголын нийгэмд хуримтлагдсан олон асуудлыг шийдвэрлэх, Монголын ирээдүйг тодорхойлоход АН-ын хүлээх түүхэн үүрэг их билээ. Өнөөгийн Монголын нийгэмд тулгарсан хүндрэл бэрхшээл, сорилт бол засаглалын чадавхи сул, улс төрийн намуудын төлөвшлөөс улбаатай гэж үзэж байгаа. Монголын ард түмэн ардчиллыг, АН-ыг байнга дэмжиж, ихийг хүлээдэг. Харамсалтай нь тэр итгэлийг манай нам дааж чадахгүй байна. Энэ нь намаа олон фракцад хуваасан, дүрмээ мөрддөггүй, боловсон хүчний зөв бодлого баримталж чадаагүй гээд олон шалтгаантайг та бүхэн мэдэж байгаа байх. Тиймээс АН-ыг тогтсон үзэл баримтлалтай, тогтвортой бүтэцтэй, судалгаанд суурилсан хөгжлийн бодлоготой, цэгцтэй боловсон хүчний бодлоготой болгох хэрэгтэй байна. Түүнчлэн улс төрийн өрсөлдөөний шинэ соёлтой, нээлттэй, өрсөлдөх чадвартай улстөрийн хүчин болгох шаардлага, зорилт, сорилт тулгарч байгаа. Ийм нөхцөлд Ардчилсан намын бодлого, үйл ажиллагааг намын гишүүд, олон түмний оролцоотойгоор улс орны ирээдүйн хувь заяа, эрх ашигт нийцэхүйц байдлаар шинэчлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, АН-ыг ардчиллын суурь үнэт зүйлсийг мэддэг дээдэлдэг, эрхэмлэдэг залуу үеийнхнээр бэхжүүлэхийг цаг үе шаардаж байна. Энэхүү шинэтгэл, шилжилтийн хариуцлагатай, эгзэгтэй цаг үед миний бие ямагт үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, АН-аа нэг цул байх ёстой гэж үзэж ирсэн. Энэ удаад уг байр сууриа дахин нотолж, хуримтлуулсан төрийн болонулстөрийнажлынтуршлага, эдийн засаг, улс төр, хууль цааз, гадаад харилцааны мэдлэг боловсролоо АН-ын намынхаа шинэтгэлийн үйлсэд зориулах нь зүйтэй гэж шийдсэнээ та бүхэнд мэдэгдэж байна” гэлээ. Тиймээс П.Цагаан дарга Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын ажлаа өгч, АН-ын шинэчлэлийн ажилд гар бие оролцохоор болж байгаа ажээ. Энэ талаараа тэрбээр “Аливаа шинэтгэлийг түүнийг зайлшгүйг ойлгосон, мэдэрсэн, бас хэрэгжүүлэх чин хүсэл эрмэлзэлтэй хүмүүс л хийдгийг би мэднэ. Энэ амаргүй үйл хэргийг манлайлж, хатаагдсан ахмад үе, ид жагсаж яваа дунд үе, ихийг бүтээх өрнүүн эрмэлзлэлтэй залуу үеийнхний холбоос, гагнаас, гүүр нь болон хамтран ажиллаж, зохион байгуулж хүссэн үр дүнд хүргэж чадна гэдэгтээ итгэлтэй байна” хэмээлээ.

*Ингээд тэрбээр сэтгүүлчдийн асуултад хариуллаа.*

**-АН-ын шинэчлэлийг яаж хийх юм бэ?**

-Намын шинэтгэл гэдэг бол нэг хүний ажил биш. Нийт намын гишүүдийн, олон хүний буюу багийн ажил. Бид намаа шинэчлэнэ. АН судалгаанд суурилсан, боловсон хүчний бодлоготой, үзэл баримтлалтай, ардчилалын суурь үнэт зүйлийг мэддэг, судалдаг, залуу үеийнхнээр бэхжүүлэх болно. Ер нь хийх ажил маш их байгаа.

**-АН олон фракцтай. Таны шинэчлэлийг намын эдгээр фракцууд дэмжих болов уу?**

-Ер нь намын гишүүд фракцгүй байх ёстой. Уг нь АН гэдэг чинь өөрөө нэг том фракц байхгүй юу. Гэтэл тэр фракц гэдэг чинь жижигрэх тусмаа Тангадын Галсан гуайн хэлдэг шиг хуваагдахын хүрд болдог. Тиймээс АН улс төрийн шинэ соёлыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. 26 жил болчихлоо. Улс төрийн шинэ соёл, өрсөлдөөний шинэ соёлыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Улс орны ирээдүйн хувьд заяаг АН шийдвэрлэх үүрэгтэй байх ёстой юм байна гэдгийг өнгөрсөн түүх болоод өнөөдрийн амьдрал амьдрал харуулж байна. Өнөөдөр Монгол Улсад хуримтлагдсан асуудлыг шийдэж байгаа байдлыг харсан ч АН шийдвэрлэх үүрэгтэй байх ёстой гэдгийг харуулж байна. Уг нь ард түмэн АН-ыг дэмждэг, том зүйлийг хүлээдэг. Харин тэдний хүлээлт буюу итгэсэн итгэлийг нь дааж чадахгүй алдаж, мунгинаад байгаа болохоос. Одоо эрийн цээнд хүрлээ. Шинэчлэгдэх цаг хангалттай болсон гэж үзэж байна.

> ...Энэхүү шинэтгэл, шилжилтийн хариуцлагатай, эгзэгтэй цаг үед миний бие ямагт үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, АН-аа нэг цул байх ёстой гэж үзэж ирсэн. Энэ удаад уг байр сууриа дахин нотолж, хуримтлуулсан төрийн болон улс төрийн ажлын туршлага, эдийн засаг, улс төр, хууль цааз, гадаад харилцааны мэдлэг боловсролоо АН-ын намынхаа шинэтгэлийн үйлсэд зориулах нь зүйтэй гэж шийдсэнээ та бүхэнд мэдэгдэж байна” гэлээ...

**-Таныг ажлаа өгөөд АН-ын дарга болно гэсэн яриа байна. Энэ тухайд?**

-Манай намын ҮЗХ-ны хурал маргааш /өнөөдөр/ 14:00 цагт болно. Намын дарга болон ЕНБД сонгуулийн үр дүнгээс хамааран улс төрийн хариуцлагаа хүлээх ээ мэдэгдсэн. Маргааш /өнөөдөр/ хурал дээр асуудлууд шийдэгдэх байх. Намын шинэчлэл олон хүний оролцоотой хийгдэх ёстой. Ардчилсан намын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хэрэгтэй байна. АН-ын даргыг энэ оны арванхоёрдугаар сарын 26 хүртэл их хуралдаа бэлтгэнэ. Арванхоёрдугаар сарын 6-ны өдөр шинэ удирдлагатай болно гээд мэдэгдчихсэн байгаа. АН-ын даргын тухайд бүгд л энэ марафонд зүтгэх гэж байгаа биз дээ.

**-Ерөнхийлөгчтэй ярилцсан уу. Таны энэ шийдвэрийг дэмжиж байгаа юу?**

-Ерөнхийлөгчтэй ярилцсан.

**-Та аль фракцийг төлөөлөх вэ?**

-Би аль нэгэн фракцийг төлөөлдөггүй. АН бол нэг том цул фракц байх ёстой гэж үздэг. Энэ байр суурьндаа үнэнч байсан. Цаашид ч байр сууриа баримтлах болно гэж үзэж байгаа.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## АН-ын ҮЗХ-ны хурлын үеэр гэнэтийн бэлэг барина гэв

“Нээлттэй Ардчилсан Нам-Шинэчлэлийн нэгдсэн хөдөлгөө”-нөөс АН-ын Үндэсний Зөвлөлдөх Хорооны /ҮЗХ/ гишүүдэд хандаж өнөөдөр болох ҮЗХ-ны хуралдааныг хэвлэл мэдээлэл, олон нийтэд нээлттэй явуулахыг уриалж мэдээлэл хийлээ. Тус хөдөлгөөний зохицуулагч, үүсгэн байгуулагч Д.Сайнбаяр “АН-д шинэчлэл хэрэгтэй болсон, ард түмэнч шинэчлэлийг хүлээж байгаа учраас манай хөдөлгөөн байгуулагдсан. Намын зүгээс биднийг сонсч байгаа. Үүний илрэл болж намын дэргэд шинэчлэлийн хороо байгуулаад байна. ҮЗХ-ны хурал хаалттай болж хэвшсэн хэдий ч зарчмынхаа дагуу хурал нь нээлттэй явагдах ёстой. Хаалттай хуралдах шаардлагатай зарим асуудлууд байж болох ч хурлаар ямар асуудлуудыг хэлэлцэх, тэдгээрийн аль нь хаалттай хэлэлцэгдэх шаардлагатай байгааг тодорхойлон хуралдааныг хаалттай горимд шилжүүлээд явах боломжтой” хэмээлээ. “Нээлттэй АН-Шинэчлэлийн нэгдсэн хөдөлгөөн”-өөс гурван шалтгааны улмаас ҮЗХ-ны хурлыг нээлттэй явуулах шаардлагатай гэж үзэж байгаа аж. Тодруулбал, АН-ын ҮЗХ-ны гишүүд нь дунд шатны намаас сонгогдон тэднийг төлөөлж ажилладагийнх нь хувьд намын гишүүд ҮЗХ-ны хурлын үйл ажиллагааг ажиглах эрхтэй. Хэдийгээр ҮЗХ-ны сонгуулийг явуулаагүй удсан ч та бүхнээс АН-ын шинэчлэлийг эхлүүлэх чухал асуудлыг хэлэлцэн зөв шийдвэр гаргана гэж намын гишүүд итгэж байна. Намын шинэчлэлийг эхлүүлэх, намын даргыг сонгох зэрэг асуудал нь зөвхөн АН-ын гишүүд төдийгүй олон нийтийн анхаарах ёстой чухал асуудал. Өнгөрсөн хугацаанд ҮЗХ-ны хурлыг хаалттай явуулдаг болсноор АН-ын дотоод ардчилал, хариуцлагын механизмд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагаа нь олон нийт, намын гишүүдийн хараа хяналтын гадна үлдэж явцуу эрх ашгийн төлөөлөл, фракцын хүрээнд шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байгаа ажээ. Дашрамд дуулгахад, тус хөдөлгөөний зүгээс ҮЗХ-ны хурлыг үеэр гэнэтийн бэлэг барина гэдгээ хэллээ.

## ГХЯ-наас сэрэмжлүүлж байна

Тайландын өмнөд хэсэгт орших Паттани мужид хоёр удаа дэлбэрэлт болсон харамсалтай хэрэг энэ сарын 23-нд гарсан. Уг дэлбэрэлтийн улмаас нэг хүн амь үрэгдэж, 30 гаруй хүн шархаджээ. Мөн наймдугаар сарын 12-нд Прачуап Кири Кан, Пукет, Сури Тани, Тран зэрэг дөрвөн мужид есөн удаа дэлбэрэлт болж, дөрвөн хүн амь үрэгдэж, 36 хүн бэртэж гэмтсэн байна. Дэлбэрэлт болсонтой холбогдуулан Тайландын өмнөд хэсгийн зарим мужид онц байдал зарлаж, харуул хамгаалалтыг чангатгажээ. Тиймээс ГХЯ-наас дэлбэрэлт болсон мужуудад гадаад, дотоодын жуулчид олноор зорчдог тул манай улсын иргэд Тайландад зорчихдоо сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

## БНСУ-ын Элчин сайд монгол далайчдыг хүлээн авч уулзлаа



Далайд гарцгүй манай улсын хувьд шинэ тутам хөгжиж буй далайн тээврийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг ОХУ, БНСУ, Швед, БНХАУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэж эхлээд даруй 10 орчим жил болоод байгаа билээ. Сүүлийн жилүүдэд хамтын ажиллагааны хүрээнд үндэсний боловсон хүчнийг БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын институт бэлтгэх болсон. Тус институтэд хөлөг онгоцны удирдлага, хөдөлгүүрийн инженер мэргэжлээр дөрвөн оюутан амжилттай суралцаж, төгсөөд салбартаа ажиллаж байгаа юм. Тэгвэл одоо хоёр оюутан мөн суралцаж байгаа аж. Тэднийг Монголын анхны далайчин Э.Энхбаярын хамт их далайд дадлагажихаар удахгүй гарах гэж байгаатай холбогдуулан БНСУ-аас Монголд суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд У Сун хүлээн авч уулзлаа. Түүнчлэн уулзалтад Далайн захиргааны дарга Х.Энхбаатар, мэргэжилтэн О.Дашбалбар нар далайчдын хамт оролцсон бөгөөд уулзалтын гол сэдэв далайчны виз олголтыг хөнгөвчлөх асуудалд дэмжлэг туслалцаа авах, хоёр орны далайн тээврийн салбар дахь хамтын ажиллагааг хэрхэн өргөжүүлэх талаар санал солилцлоо. Элчин сайд У Сун тус асуудлыг яамны зүгээс судлан тусалж, дэмжихээ мэдэгдсэн юм. БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын институтийн 2017 оны шинэ хичээлийн жилд Монгол Улсаас дөрвөн оюутан шинээр суралцахаар болсныг онцлон тэмдэглэхэд таатай байна.

ШАР МЭДЭЭ

## Ерөнхийлөгч барилгачдаа шагнахаас татгалзсан

Х.НОРЖИН

Хэдхэн хоногийн дараа буюу ирэх есдүгээр сарын 8-9-ний өдрүүдэд барилгын салбарынхан түүхт 90 жилийнхээ ойг тэмдэглэнэ. Эсгий гэрийг орд харшаар сольж чадсан, Монгол Улс хөгжлөөрөө дэлхийд нэртэй, нүүртэй яваагийн цаана үе үеийн барилгачдын хөдөлмөр зүтгэл буй билээ. Харамсалтай нь Монгол Улсын Ерөнхийлөгч барилгачдаасаа нүүр буурууулж, төрийн дээд одон медаль өгөхөөс гар татсан сурагтай. Нуруугаа бөгтийтөл, хөлөө майжийтал тоосго үүрч зүтгэсэн хэчнээн барилгачин 90 жилийнхээ ойгоор төрийн дээд шагнал хүртчих байх хэмээн горьдож суугаа бол. Хүн гээч урмын “амьтан” юм гээ биз дээ. Монголчууд шагналд дуртай л даа. Тэр хэрээр бүтээдэг, туурвиж ирсэн болохоор зарим тохиолдолд гар татганаж, улстөржилгүйгээр хүртээх ёстой шагналыг нь өгчихөж баймаар юм. УИХ-ын сонгууль ойртохоор нэр дэвшигчдийн цүнхэнд уут уутаараа явдаг юм билээ, тэр тэргүүний ажилтан цол тэмдэг чинь. Н.Энхбаяр ерөнхийлөгчийн үед Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль Москва дахь Монгол Улсын ЭСЯ-ны коридорт хайхрах, тоох эзэнгүй шуудайгаараа хэвтэж байсныг нь сэтгүүлчид мэднэ дээ. Төр нь мөнгөгүй, хямарч ядаж байгаа энэ цаг үед барилгачид маань энгэртээ гялалзах одон медалиа ч болов хараад баярлацгаах л байсан юм, уг нь.

## ҮЗЭЛ БОДОЛ

# АРДЫН НАМ АРД ТҮМЭНДЭЭ ТОМООС ТОМ “САЛААВЧ” ӨГЛӨӨ

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

### Алтадсан өрөө, албан тушаалд хэмнэлт гарсангүй

Тодруулбал, Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн Засгийн газарт өргөн мэдүүлсэн 2016 оны Төсвийн тодотгол дандаа хасч танана, халамжийг үгүй болгоно, зогсооно гэсэн заалтууд оржээ. Тэр нь дандаа иргэдэд чиглэж байсан хөтөлбөр, халамжийн бодлогууд. Төрийн албаны тансаглалыг зогсоох тухай заалт ганц, нэгхэн байгаа. Мэдээж үр ашиггүй халамжийг зогсоож, зорилтот бүлгээ тойглох зарим санааг нь буруутгах аргагүй. Харамсалтай нь, тэдний ам ажил хоёр алд дэлэм зөрчихөж. Хотын дарга Су.Батболд нь алтаар чимэглэсэн албан өрөөндөө арабын шах шиг тухалчихсан суугаа зураг цахим ертөнцөөр нэг цацагдав. Өмнөх Засаг дарга Э.Бат-Үүлийн өрөөнөөс 100 хол давсан тансаг өрөөндөө сувинер дүүртэл өрчихөөд, малийж суугааг нь харахаар улс тэгтлээ хямарчихаагүй юм шиг санагдах юм. Ж.Эрдэнэбат сайдын өрөөг ч гэсэн Ч.Сайханбилэгийн сууж байсантай харьцуулахад хол давсан тансаг харагдах аж. Албан өрөөндөө завсар үйлчилгээ хийж, алтадсан багана босгож тансаглах тэднийг харахаар бид тэгтлээ хямраагүй юм биш үү хэмээн асуумаар. Нөгөө талаар, МАН-ынхан албан тушаалын томилгоог өнгөрсөн өдрүүдэд хэтэрхий хайнга хийлээ. Гарын үсэг зурах ч эрх мэдэлгүй бэлгэдлийн төдий дэд сайдын орон тоог нэмсэн нь худлаа биш. Бүр нөлөө бүхий улстөрчийн нөмөрт явдаг бүсгүйд зориулж шинэ агентлаг хүртэл нэмсэн тухай яриа цахим ертөнцөд эрчээ аваад байгаа. Үнэхээр л улсын төсөв хоосорч, улсаараа дампуурч байгаа бол энэ тансаглал, үр ашиггүй албан тушаал хэнд хэрэгтэй гэж. Дэд сайдын албан тушаалд сууж буй хүмүүс хэдэн төгрөгийн хангамж, машин, цалин авахыг тооцоод үзвэл 800 мянган хүүхдэд өгч буй 20 мянган төгрөг дэргэд нь юу ч биш байлтай.

### Ядарсан түмэндээ барьж буй МАН–ын гэнэтийн бэлгүүд

МАН-ын 2016 оны бүх шатны сонгуульд барьж орсон мөрийн хөтөлбөрийг тоймловол иргэдээ ядуурлаас аварч, эдийн засгаа хямралаас гаргаж, эх орноо өрнөөс салгаж, төрийн дампуурлыг засч, тэгш журамт баян хүчирхэг Монголоо цогцлоох тухай тусгасан. Цаашлаад, хүүхэд бүрт мөнгө өгнө, эхчүүдийн халамжийг нэмэгдүүлнэ, оюутны 70200 төгрөгийг үргэлжлүүлэн олгож, гурваас дээш хүүхэд нь сурдаг бол төрөөс бодлогоор халамжилж, оюутан залуус сургалтын зээл авч суралцах орчныг бүрдүүлнэ, дөрвөөс дээш хүүхэдтэй гэр бүлийг орон сууцтай болгоно, татвар нэмэхгүй, тэтгэврийн зээлийн хүүг бууруулж, тэтгэвэрт гарах насыг наашлуулна гэх мэтээр цуварч өгнө. Ахмадууддаа Ач санах, Насны хишиг олгох гэх мэтээр бялууртал уран үгээр тогложээ. Гэвч, энэ оны төсвийн тодотголд дурьдсан заалтууд мөрийн хөтөлбөрөөсөө 360 градус өөр. Тухайлбал, ахмад настнуудын хүсч хүлээж байсан Хамтын тэтгэврийн тухай хуулийг зогсооно. 15 жилээс дээш хамт амьдарсан настнуудын нэг нь нас барлаа гэхэд үлдэж хоцорсон нь насан эцэслэх хүртлээ тэтгэврийг нь авах эрхзүйн орчныг бүрдүүлсэн энэ хуулийг хэрэгсэхгүй орхисноор ахмадуудыг асрах, ач санах мөрийн хөтөлбөрөөсөө татгалзлаа. Цаашлаад хүүхэд бүрт олгож байсан 20 мянган төгрөгийг зорилтот бүлэгт олгох буюу нийт хүүхдийн 60 хувьд олгохоор болж, мөрийн хөтөлбөр нь хог дээр гарав. Орон сууцанд амьдардаг гэртээ хөргөгч, гаднаа машинтай бол таны хүүхэд энэ мөнгийг авч чадахгүй гэсэн үг. Оюутан бүрт олгож байсан 70 мянган төгрөгийг мөн л төсвийн тодотголоор зогсоохоор шийдсэн. Татвар нэмэхгүй хэмээн амлаж байсан тэд Хувь хүний орлогын албан татварыг нэмэх, Нийгмийн даатгалын шимтгэлийг жил бүр үе шаттай нэмэхээр болж байна. Ингэснээр ажилчдынхаа цалинг дөнгөн данган тавьж буй олон ч аж ахуйн нэгж, хувийн хэвшил дампуурлаа зарлаж, бидний авдаг цалин багасах нь. Архи, тамхинаас татвар авах нь буруу хэмээн Үүл баатрын эсрэг дайн зарлаж байсан МАН-ынхан нэгхэн жилийн дараа эсэргүүцлээ мартаж орхиод архи, тамхины онцгой албан татварын хэмжээг 20 хувь хүргэчихлээ. Таны унаж буй машин приус, Ланд-200 байхаас үл хамаарч зөвхөн үйлдвэрлэсэн оноос нь хамаарч татварыг нь нэмэв. Мөн хөдөлгүүрийн багтаамж өндөр / 4500 см3 / машин унадаг бол дахиад л хохирч, мөн л татвар нэмж төлнө. Сургалтын төлбөр гурван сая давчихаад байгаа энэ үед оюутан залуус автобусны хөнгөлөлт эдлэх эрх нь Ардын намын буянаар алга болж байна. Төрийн өмчийн компанид ажилладаг 30, 60 сая төгрөгийн цалинтнуудаас гадна төрийн албан хаагчид мөн л цалингаа хасуулах нь. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг залуусын тэтгэлгийг МАН зогсоолоо. Насаараа төрд ажиллаж, шохой идсэн багш, үхэл амьдралтай өдөр бүр тэмцэж буй эмч нарын 36 сарын цалинтай тэнцэх урамшууллыг зогсоож, ядарсан ард түмэндээ гэнэтийн бэлэг бэлджээ. Ямар хэмнэлт гэхээрээ тэтгэвэрт гарах насыг нь хойшлуулан тамлаж, бүр болоогүй 36 жил төрд ажилласных нь төлөө шийтгэж байгааг ойлгох аргагүй. Гадаадын их, дээд сургуульд суралцагчдын тэтгэлгийг 2019 он хүртэл хойшлуулахаар оруулж ирсэн ч энэ хөтөлбөрийг зогсоохгүй гэж шийджээ. Арга ч үгүй. Гадаадад сурдаг залуусын дийлэнхи олонхи нь ардын хүүхдүүд биш албан тушаалтны хүүхдүүд учраас тэднийг хоолноос нь салгаж төвдөхгүй биз. Харин эсрэгээрээ цалингийн, малчны зээлтэй аав ээждээ дарамт болохгүйгээр зээл аваад суралцах боломжийг олгож байсан “Сайн оюутан” хөтөлбөрийг тэд зогсоожээ. 10 хувийн хүүтэй зээл авч байсан малчдынөмнөөсардынхаатөлөө ажилладаг нам нь томоос том “салаавч” өгчихлөө. МАН-ын энэхүү халамжийг танах тухай бодлого хасах танах бүлгээ олж чадсангүй. Шүүгчийн цалинг бууруулах, оюутны 70 мянга, 30, 60 саяын цалинтнуудыг эс тооцвол ядарсан ард түмний амьдралд бага ч болов нэмэр тус болж байсан халамжийн бодлогуудыг зогсоож байна. Хатуухан хэлвэл, халамжаа санасан монголчуудад салаавч өгчихлөө. Хамгийн зальтай нь энэхүү хэмнэлт таналтыг МАН дандаа түр зогсоож байгаа. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өмнөх жил эргэж сэргээгээд л нэг жилийн хугацаанд бялууртал нь мөнгөөр угжина гэсэн үг. Нүүрс, алт, орд газраа барьцаалаад ч болов түр зогсоосон хөтөлбөрөө түргэхэн шиг хэрэгжүүлж эхэлнэ. Гурван жил чардайтал бүсээ чангалсан монголчууд нэг жилийнх нь мөнгөнд атга чихэр авсан хүүхэд шиг л баярлаж, ахиад Ардын намд санал өгөхийг тэд тооцоолсон нь дамжиггүй. Юутай ч хямарсан ард түмэнд дахиад гурван жил бүсээ чангалахаас өөр сонголт үлдсэнгүй. Ямар үр тариална түүнийгээ хураадаг гэгчээр ямар сонголт хийсэн түүнийхээ үр шимийг хүртэж суухаас өөр сонголт алга даа.

...Хатуухан хэлвэл, халамжаа санасан монголчуудад салаавч өгчихлөө. Хамгийн зальтай нь энэхүү хэмнэлт таналтыг МАН дандаа түр зогсоож байгаа. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өмнөх жил эргэж сэргээгээд л нэг жилийн хугацаанд бялууртал нь мөнгөөр угжина гэсэн үг. Нүүрс, алт, орд газраа барьцаалаад ч болов түр зогсоосон хөтөлбөрөө түргэхэн шиг хэрэгжүүлж эхэлнэ. Гурван жил чардайтал бүсээ чангалсан монголчууд нэг жилийнх нь мөнгөнд атга чихэр авсан хүүхэд шиг л баярлаж, ахиад Ардын намд санал өгөхийг тэд тооцоолсон нь дамжиггүй...

**1. Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болгох (Нас барсан эхнэр, нөхрийнхөө тэтгэврийг хань нь үргэлжлүүлэн авах боломжийг хуульчилсныг болиулах)**
**2.Тэтгэврийн насыг нэмэх**
**3. Хувь хүний орлогын албан татварыг нэмэх, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэх (Авдаг цалин чинь багасна)**
**4. Оюутны 70 мянгыг зогсоох**
**5. Хүүхдийн мөнгийг зогсоох (40 хувь нь хүүхдийн мөнгө авахгүй6 Гэртээ угаалгын машин, гаднаа унадаг машинтай бол хүүхдийн мөнгөнөөс мултарлаа гэсэн үг)**
**6.Онцгой албан татварын хувь хэмжээг архи, дарс, тамхинд 20 хувь, суудлын автомашинд үйлдвэрлэсэн оноос хамаарч 3-15 хувийн татвар нэмэгдүүлэх;**
**4. Хөдөлгүүрийн багтаамж өндөртэй (4500см3-ээс дээш) суудлын автомашинд ногдуулах онцгой албан татварыг нэмэгдүүлэх**
**5.Автобусны хөнгөлөлтийг байхгүй болгох**
**6. Т38, АА6 албан тушаалуудын цалин 20 хувь буурна (Өнөөх 30, 60 саятнуудаас гадна)**
**7. Бүх сайн хөтөлбөр зогсов (Оюутнууд 5 хувь, малчид 10 хувийн хүүтэй зээл авдаг байсныг хорьчихсон)**
**8. 2016-2019 онд гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахгүй.**
**9. Төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахдаа 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж авдаг байсан. Үүнийг болиулж 1-12 сарын дундажтай тэнцэх мөнгө өгнө. Насаараа төрд ажиллаад тэтгэвэрт гарахдаа нэг сарынхаа цалинг л авах нь.**
**10. МСҮТ-д суралцдаг оюутнууд цалин авдаг байсныг зогсоох.**
**11. Шүүгчдийн цалинг бууруулах.**




Дугаарын 60 мөр

## Ухаалаг системд шилжсэнээ мартаад байна уу даа

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Эсвэл ухаалаг системд шилжсэнээ мартчихаад заавал зургийг нь харж, амьд бодь галтай нь тулгаж гэмээнэ баараггүй гэж санадаг байх. Тэгээд ч манай улсын Үндсэн хууль хийгээд иргэнтэй холбоотой хууль тогтоомжид “Монгол Улсын иргэн нь бичиг баримтаа биедээ заавал авч явна” гэсэн зүйл заалт байдаггүй. Нөгөөтэйгүүр, халаасны хулгайн асуудлыг Хятад шиг төгс зогсоож чадаагүй учраас иргэд аль болох бичиг баримтаа биедээ авч явахгүйг хичээдэг. Гай таарч алдчихвал дор хаяж 10 хоног ажлынхаа дундуур гүйж хөөцөлдөх хэрэгтэй болдог. Энэ мэт асуудлыг шийдэх үүднээс ухаалаг системд шилжүүлсэн бус уу. Ингэж асар их хэмжээний төсөв хөрөнгө зарж байж нэвтрүүлсэн ухаалаг системийн ачаар монголчууд ТҮЦ машинд хуруунихаа хээг уншуулаад л бүхий л лавлагаа мэдээллээ авдаг болсон. Тусгай нууцлал бүхий цаасан дээр хэвлэгддэг учраас хэн нэгэн өөртэйгөө холбоотой муу муухай саар мэдээллээ засч янзлаад хэвлэх боломжгүй. Ийм атал цагдаа нар заавал жолооны үнэмлэхээ биедээ авч явахыг шаардаж, байхгүй гэвэл торгоно гэж дайраад байгаагийн учрыг гайхаад олохгүй юм. Бид хааяа гэрээсээ гарахдаа хэтэвчээ мартах, цүнхээ солиод гарахдаа жолооныхоо үнэмлэхийг анзааралгүй үлдээчихдэг гэмтэй. Ийм тохиолдолд цагдаа нар машины дугаар эсвэл тухайн иргэний регистрийн дугаараар хөөгөөд жолооны үнэмлэхтэй эсэхийг нь мэдэж болох байлтай. Эдүгээ замын цагдаа нарын ашиглаж буй техник тоног төхөөрөмж дэлхийн жишигт очсон. Бүсэндээ зүүж яваа автомат машинаа ашиглаад жолоочийн талаархи мэдээллийг авч, алдаа гаргасныг нь торгож болоод байгаа юм чинь нэг удаа жолооны үнэмлэхээ мартсан нэгнийг замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргаагүй бол мэдээлэл рүү нь орж танилцаад жолоо барих эрхтэй байх аваас торголгүйгээр явуулчихаж болмоор доо. Иргэний болоод жолооны үнэмлэхийг цахимжуулсны цаад утга учир нь ердөө энэ. Эсвэл манай замын цагдаа нар бүсэндээ зүүсэн багажаа тэр бүр ашиглаж чаддаггүй юм болов уу. Асуудлыг бас өөр өнцгөөс харж болно. Бүх зүйл ухаалаг системд шилжин иргэдийн ухамсар тэр хэрээр сайжирч, замын хөдөлгөөнд оролцох үедээ алдаа гаргахгүйг хичээх болсноор Замын цагдаагийн газрын улсын төсөвт нийлүүлдэг мөнгөний хэмжээ багасч, сар, жил, улирлынх нь төлөвлөгөө тасрах дээрээ хүрч балардаг болоод өчүүхэн жижиг дутагдалд ч торгууль ногдуулах үүрэг даалгаврыг дээд газраасаа авдаг юм болов уу. Эсвэл хэдэн иргэнд торгууль торгууль ногдуулснаараа өрсөлдөж, үнийн дүн өндөр хувьтай нь байгууллагынхаа аварга болдог юм болов уу. Тэгвэл үнэнээ л хэл л дээ. Жолооч нар ойлгоно.

ЧУХАЛ СЭДЭВ



# Б.МӨНХЗАЯА:

# ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ХЯЗГААРЛАХГҮЙ БОЛ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТ ЗОГСЧИХЛОО

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэхдээ яах вэ, төр засгийн удирдлага солигдсон. Монголбанкны удирдлагууд ч өөрчлөгдлөө. Шинэ Засгийн газар одоо алдаагаа засаад, бидний санаа бодлыг тусгаад ажиллах байх гэж найдаж байна.

**-Өнөөдрийн яриад байгаа шиг эдийн засаг тэгтлээ хүндэрчихсэн юм уу. Ард түмэн янз бүрийн мэдээлэл дунд төөрөөд л байна шүү дээ?**

-Эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх үзүүлэлттэй нь харьцуулахад одоо завсарын үедээ л байна гэж би хэлнэ. Эдийн засгийн сайн үзүүлэлтүүд саарчихсан байна. Гэхдээ ёроолд буюу гамшгийн түвшинд хараахан хүрээгүй байгаа. Дээшээ явах уу, доош нь унагах уу гэдэг нь одоо хэрэгжүүлэх бодлогуудаас хамаарна. Би бол аюултай хэмжээндээ тулчихсан гэж ерөөсөө бодохгүй байгаа. Бусад орнууд үүнээс илүү хүнд байдалд орж л байсан. Тэдний болоод өнгөрсөн 10 гаруй жилийн үзүүлэлттэй харьцуулаад харахад, яг дунд нь л байгаа. Харин муу тал нь гэвэл чиглэл дээшээ биш доошоо байгаад байна.

**-Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэхийн хэрээр банкны салбарт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь тодорхой. Банкны секторын өнөөгийн бодит байдал ямар байна?**

-Өнөөдрийн тоон үзүүлэлтүүдийг харахад, банкны салбарт байгаа чанаргүй зээл өссөн дүр зураг ажиглагдаж байгаа ч гэсэн аюулын хэмжээнд хүрээгүй. Одоогоор арилжааны банкууд Олон улсын зохицуулах байгууллагаас гаргасан зарчмын дагуу боловсруулсан зохистой харилцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаад явж байгаа. Харин миний яриад байгаа зүйл бол эдийн засгийг эргэлтэд оруулах чиглэлд анхаарахгүй бол нөхцөл байдал бүр хүндэрнэ. Бизнесийн салбарынхан үйл ажиллагаагаа явуулаад, хүмүүс ажилтай байгаа нөхцөлд банкны салбар одоогийн эрсдэлээ даваад гарчихна. Харин эдийн засаг улам хүндрээд ирвэл дагаад банкны салбар хүндрэх асуудал яригдаж ирнэ шүү дээ. Түүнээс биш яг өнөөдрийн байдлаар банкны систем уналтад орчихсон, аюул нүүрлэсэн зүйл алга.

**-Монголбанк саяхан бодлогын хүүгээ нэмсэн. Энэ шийдвэрийг дагаад арилжааны банкны зээлийн хүү нэмэгдэж, иргэд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид улам л хэцүүдэх нь гээд байгаа. Энэ тал дээр та ямар байр суурь илэрхийлэх вэ?**

-Төв банкны хүүг суурь хүү гэж авч үздэг. Суурь хүү дээр тодорхой хувь нэмэгдээд зах зээлийн хүү тогтдог гэж үздэг. Суурь хүү нь өсчихсөн учраас банкны хүү тодорхой хэмжээнд өсөх байх гэж бодож байна. Гэхдээ бодлогын хүүний өөрчлөлт зах зээл дээр шууд мэдрэгдэхгүй шүү дээ. Жишээлбэл, өнөөдөр Төв банкны үнэт цаасны хүү 4.5 хувиар нэмэгдлээ гээд зээлийн хүү шууд тийм хэмжээнд нэмэгдэнэ гэсэн ойлголт байхгүй. Арилжааны банкууд эх үүсвэрийнхээ зардлыг өсгөсний дараа зээл орж байгаа. Тийм болохоор шууд нөлөө тийм хүчтэй гарч ирэхгүй болов уу. Харин Төв банкны үнэт цаасны хүү 15 болсонтой холбоотойгоор иргэд хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх шаардлага тавьж болно. Эсвэл хадгаламжийн хүүгээ өсгөхөөс өөр аргагүй нөхцөл байдалд хүрсэн тохиолдолд л зээлийн хүү өсөх байх гэж бодож байна. Мэдээж бодлогын хүү нэмэгдсэнээр нөлөө гарах ч богино хугацаанд зээлийн хүү огцом өсөхгүй гэж харж байгаа.

**-Монголбанкны зүгээс өнөөдрийн нөхцөлд бодлогын хүүгээ 15 хувь болгохоос өөр зөв зам байхгүй гэсэн тайлбарыг өгөөд байгаа. Үнэхээр үүнээс өөр зөв зам байгаагүй юм болов уу?**

-Аливаа асуудалд ганцхан шийдэл гэж байдаггүй. Олон хувилбар байдаг. Олон хувилбаруудаа үнэлж үзэж байгаад л аль нэгийг нь сонгож байгаа байх. Би Монголбанкны шийдвэр зөв гэж өмөөрөхгүй, буруу гэж буруутгахгүй байгаа. Олон хувилбар байсан байх. Ийм шийдвэр гаргаж байгааг бодоход түүний цаадах үр нөлөөгөө тооцсон, дараа нь ямар арга хэмжээ авахаа төлөвлөсөн байх гэж найдаж байна. Түүнээс биш энэ нь зөв, буруу гэж хэлэх тоон мэдээлэл, судалгаа ч надад алга.

**-Улстөрчдийн амлалт эдийн засгийг утгаар нь “алж” байгаа нэг “зэвсэг” болчихоод байна. МАН-ынхан сонгуулийн өмнө зээлийн хүүг бууруулна гэж амласан. Шинэ Ерөнхий сайд ажлаа авсныхаа дараа банкны зээлийн хүүг бууруулах боломжийг судалж байна гэж ярьсан. Гэтэл одоо зээлийн хүү буурах нь битгий хэл өсөхөөр болчихлоо. Гэтэл иргэдийн ганц сонирхож, хүлээж байсан зүйл нь энэ. Ер нь Монголд банкны зээлийн хүү буурах боломж байна уу?**

> ...Гадны банкууд манайд үйл ажиллагаа явуулаад, зээл олгоё гэж бодъё. Тэгвэл тэд ямар төрлийн зээл ихэвчлэн олгох сонирхолтой байх вэ гэхээр хамгийн их өсөлттэй салбарт л мөнгөө өгөхийг хүснэ. Тэр нь юу вэ гэхээр, уул уурхай. Түүнээс биш ипотек ч юм уу бидний хүсээд байгаа салбарт зээл олгох сонирхол бага байх болов уу...

-Буурах боломж нь хөрөнгийн зах зээл л гэж би хардаг. Бизнес эрхлэгчид банкуудаас өндөр хүүтэй зээл авах биш харьцангуй бага хүүтэйгээр хөрөнгийн зах зээл дээрээс босгох хэрэгтэй. Ингэж л хөрөнгийн зах зээл болон банкны хоорондын өрсөлдөөнөөс үүдэж зээлийн хүү буурах боломжтой. Тэгэхгүй банкууд нь өндөр хүүтэй хадгаламж аваад, өндөр хүүтэй зээл гаргаад ашигтай ажиллаад байдаг. Бизнесийнхэн нь үүнээс өөр аргагүй гээд л өндөр хүүтэй зээлээ аваад байна. Гэтэл хөрөнгийн зах зээл дээр арай хямд эх үүсвэрээр зээл авах боломжтой болчихвол өрсөлдөөнөө дагаад банкны хүү буурч л таараа. Банкны хүүг өрсөлдөөнөөр л шийдэж, буулгах боломжтой. Түүнээс биш намын мөрийн хөтөлбөрт оруулаад шийдчихдэг юм биш. Ядаж байхад өнөөдөр манай улсад энэ өрсөлдөөн алга. Хөрөнгийн зах зээл нь удаашірчихсан. Тийм болохоор санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нэг номерт шийдэх ёстой асуудал. Үүнийгээ шийдэх ёстой. Дээрээс нь ямар нөхцөлд, яаж орж ирэх вэ гэдэг тооцоо судалгаа, үндэслэл, хууль эрх зүйгээ маш тодорхой болгох шаардлагатай. Тэгэхгүй гэнэтийн ашгийн татвар шиг нэг “юм” гаргаж ирснээ, жаахан ашиггүй юм шиг санагдахаар нь огт өөр зүйл хийгээд явбал гадны банкууд манайхыг сонирхохгүй шүү дээ. Тийм болохоор энэ мэт сууриа маш сайн тавьсны дараа л гадны банкуудыг оруулж ирээсэй гэж боддог. Түүнээс биш яг төдийд оруулж ирэхэд тохиромжтой гэж хэлэх боломжгүй л дээ. Төр л эрхзүйн зохицуулалтаа маш сайн хийх хэрэгтэй. Тэгэхгүй бол гадны хөрөнгө оруулагчид Монголоос яаж явж, алга боллоо доо. Түүнтэй адилхан гадны банкууд гэнэт их хэмжээний валют оруулж ирчихээд, ашиггүйгээр буцаад гараад явбал яах билээ. Энэ мэт олон асуудал байгаа.

**-Зарим эдийн засагчид гадны банк зайлшгүй орж ирэх цаг болчихсон. Тэгэхгүй бол Монголын банкны эзэд хэтэрч байна гэж яриад байгаа шүү дээ?**

-Аливаа зүйл хоёр талтай. Тийм болохоор би ийм байр суурь илэрхийлж байгаа эдийн засагчидтай санал нэг байгаа. Аливаа зүйлийн эерэг, сөрөг тал гэвэл аль алийг нь ярьж болно шүү дээ. Би оруулж ирэх ёсгүй гэсэн байр сууринаас хандахгүй байгаа. Оруулж ирэхдээ харин ямар нөхцөл бүрдүүлэх вэ гэдгээ л маш сайн анхаарах ёстой байх. Сэтгэлийн хөөрлөөр биш, ул суурьтай хандаасай. Ямар нэг эрсдэл үүсэхээр юм битгий хийгээсэй гэж хүсээд байгаа юм. Гадны банкууд орж ирвэл манай улсын банкны салбарын хөгжлийг дараагийн үе шатанд гаргах нь бол ойлгомжтой. Гэхдээ нийт системдээ аюул учруулахгүйгээр яаж үүнийг хийх вэ гэдэг л асуудал байна.

**-Банкны үйлчилгээний үнэ өртөг өдрөөс өдөрт нэмэгдээд л байна. Банкууд АТМ-аас мөнгө авах шимтгэлээ нэмж ч байх шиг. Энэ нь банкны салбар хэцүүдэж байна гэх бодлыг иргэдэд төрүүлээд байх шиг?**

-Ерөөсөө л ашиг орлоготой л холбоотой зүйл. Банкуудын ашигт ажиллагаа саарч, зээлийн чанар муудаад байгаа. Энэ үед ашгаа юугаар нөхөх билээ. Үйлчилгээнийхээ шимтгэлээр л нөхнө. Банк бол хэт их ашиг олохгүй, ашиг нь тодорхой түвшинд байх ёстой. Гүйцэтгэх захирлууд хувь нийлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргийн дагуу ашгаа тодорхой түвшинд барьж байх ёстой болдог. Хэрвээ зээлээс орж ирэх мөнгө хумигдаад байвал үйлчилгээний шимтгэлээ нэмэгдүүлж, ашгаа тодорхой түвшинд барихаас өөр яах билээ дээ. Нөгөө талаасаа тэр банкууд тогтвортой байхын тулд үйлчилгээний шимтгэлээ нэмж байгаа ч гэж тайлбарлаж болно.

**-Монголбанк бодлогынхоо хүүг нэмсний дараахан “Энэ бол дампуурах дөхсөн банкуудаа аварч байгаа арга хэмжээ” гэсэн утгатай нийтлэл гарсан байхыг уншсан. Энэ мэтээр эргэлзээ төрүүлэхээр мэдээлэл их байна л даа?**

-Миний ойлгож байгаагаар тийм зүйл байхгүй. Бодлогын хүү нэмснээр арилжааны банкууд төв банкнаас үнэт цаасыг нь худалдаж авна. Эрсдэлтэй зээл олгохоо болиод, төв банкны үнэт цаасыг худалдаад авчихаж байгаа юм. Хөрөнгө нь эрсдэлгүй, тэгэхдээ 15 хувийн ашиг олно л гэсэн үг. Хэрвээ банк дампуурах дээрээ тулчихсан бол бодлогын хүү нэмэгдлээ гээд ямар ч нэмэр болохгүй. Төв банк бодлогын хүүгээ нэмлээ ч ямар хөрөнгөө гаргаж тэнд байршуулах юм, тийм биз дээ. Харин энэ шийдвэр магадгүй банкуудыг эрсдэлгүй, арай өндөр өгөөжтэйгээр мөнгөө байршуулж, ирээдүйд дампуурахаас нь урьчилсан сэргийлсэн гэж тайлбарлавал болох байх.

**-Ипотекийн зээлийг зогсоох ёстой гэсэн санал ч гарч эхэлсэн. Уг нь барилгын салбарыг дэмжих, иргэдийн аятухтай амьдрах боломжийг хангах боломжийг хангаж байсан зээл шүү дээ. Энэ хөтөлбөр үргэлжилсэн нь дээр үү, танд ямар шийдэл харагдаж байна?**

-Ипотекийн зээлийн төвлөрөл маш их байна. Эдийн засаг эргэлдэж байхын тулд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбаруудаа дэмжсэн хөрөнгө оруулалт байх хэрэгтэй. Гэтэл энэ бүхэн зогсонго байдалд орчихсон. Нөгөө талаасаа эдгээр бизнес явж байгаа тохиолдолд иргэд худалдаж авах мөнгөтэй байх ёстой. Харин одоо бол хүмүүс бүх хэрэглээгээ хумьчихсан. Инфляци өсөхгүй байгаагийн шалтгааныг хүмүүс хэрэглээгээ илт багасгасантай холбоотой. Цалингаа авлаа, мөнгөө орон сууцны зээлээ төлдөг. Өөр зүйл худалдаж авч идэж, ууж, өмсч зүүж, эдийн засгийг эргэлтэд оруулж, үнийн өсөлтийг бий болгох байтал тэр хөрөнгө ганцхан орон сууцны зээл рүү явчихаад байгаа юм. Энэ тохиолдолд эдийн засаг яаж өсөх вэ. Хүмүүсийн хөрөнгийг хааш нь чиглүүлэх вэ гэдэг урсгалыг зохицуулахын тулд ипотекийн зээлийг тодорхой хэмжээнд хязгаарлах хэрэгтэй л гэж боддог. Одоогоор төвлөрөл ихтэй нэлээд хэмжээгээр олгочихсон шүү дээ. Тиймээс нэмж олгох шаардлагагүй гэж бодож байна.



# ОНЦЛОХ ХУУДАС

# ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨР НЭМЭГДЭХГҮЙ

Н.БАТЗАЯА

*Их, дээд сургуулийн хичээл эхлэхэд долоо хоног үлдсэн. Тиймээс төрийн өмчийн сургуулийн төлбөр нэмэгдсэн эсэх талаар сургуулиудын захирал болон албаны хүмүүстэй холбогдож “speak out” хийлээ.*

## Р.Бат–Эрдэнэ: 2016–2017 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг нэмээгүй

*/Монгол Улсын их сургуулийн захирал /*



-Манай сургуулийн сургалтын төлбөр нэмэгдээгүй. Өмнөх жилийн төлбөрөөрөө байгаа. Энэ жил сайд төлбөрийг нэмэгдүүлэхгүй байх чиглэл өгсөн. Тэр дагуу манай сургууль төлбөрөө нэмээгүй. Мөн удирдах зөвлөлийн зургадугаар сарын 13-ны гуравдугаар тоот тогтоолоор 2016-2017 оны хичээлийн жилийн бакалаврын төвшний сургалтын төлбөрийг баталсан. Уг тогтоолд зааснаар курсээсээ хамаарч өөр өөр үнэтэй байгаа. Тухайлбал, Шинжлэх ухааны сургуулийн нэгдүгээр курсийн нэг багц цагийн төлбөр 80.200, хоёрдугаар курс 74.600, 3-4 дүгээр курс 64.600 төгрөгийн үнэтэй. Хэрэглээний шинжлэх ухааны сургууль 1-2 дугаар курс 80.200, 3-4 дүгээр курс 69.100 төгрөг болсон. Ер нь нэг багц цагийн төлбөр 46-96 мянган төгрөгийн хооронд бий. Мөн манай сургуулийн нэрэмжит тэтгэлэг байдаг. Бид бакалаврын төвшний суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй шилдэг оюутныг урамшуулах, зарим мэргэжлээр элсэгчдийг дэмжих зорилгын хүрээнд уг тэтгэлгийг олгодог. Тэгэхдээ улсын чанартай олимпиадад амжилттай оролцож, медальт байр эзэлсэн оюутнуудад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг.

## Б.Очирбат:Төлбөрөө огт нэмээгүй

*/Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал/*




-Жил бүр хичээлийн жилийн нэг кредитийн үнэлгээг гаргадаг. Манай сургууль энэ жил 2015-2016оныхичээлийнжилийннэгкредитийн үнэлгээг дагаж, мөрдөхөөр шийдвэрлэсэн. Нэг үгээр хэлбэл, сургалтын төлбөр нэмэгдээгүй байгаа гэсэн үг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын их, дээд сургуулийн төлбөрийг нэмэхгүй гэдэг тушаал гарсан учраас бид ингэж шийдсэн юм. Сургалтыг төлбөрийг огт нэмэгдүүлээгүй. Өмнөх хичээлийн жилийн үнэлгээг мөрдөж байна. Төлбөрийн хувьд курсээсээ хамаараад харилцан адилгүй. Тухайлбал, нэгдүгээр курсийн нэг кредитийн үнэлгээ 61813, бусад курс нь 56868 төгрөг байгаа. Өнгөрсөн жил ч ийм байсан. Ер нь нэг кредитийн дундаж үнэлгээ 59300 болж байгаа юм. Тэгэхээр нэг оюутан жилд 30 кредит судална гэж үздэг.  Нэг кредитийн үнэлгээг нийт кредитдээ үржүүлвэл ойролцоогоор нэг сая 800 мянган гарч байгаа. Дундаж төлбөр нь шүү дээ. Гэхдээ оюутан жилд 29 кредит хичээл судалж болно. 31 кредит ч судалж болно. Сонгож байгаа хичээлээсээ хамаараад судлах кредит өөр байдаг. Мөн энэ жил улс орны эдийн засаг хямралтай байгаа учраас сургалтын төлбөрийг хагас жилээр авахаар болсон. Хагас жилээр төлбөрийг нь авбал дунджаар 15 кредит хичээлийн мөнгө авах юм. Бид нэгдүгээр курсийн оюутнуудад заавал судлах ерөнхий хичээлийн талаар жишиг зөвлөгөөг өгдөг. Ингээд бодохоор эхний семистерт 850-900 мянган төгрөг л авч байна. харин үлдсэн төлбөрөө дараа семистертээ өгнө. Төлбөрийн уян хатан нөхцөлийг сонгож, оюутнуудад боломж олгосон. Бүртгэлийн ажил мэргэжлээсээ хамаараад харилцан адилгүй байна. Зарим нь дүүрсэн, зарим нь дүүрээгүй л байна. Бүртгэлийн ажил ШУТИС-иййнхаа байдлаар дунджаар 60 хувьтай явагдаж байна. Одоо ч үргэлжилж байгаа. Энэ долоо хоногийг дуустал явагдана. “Төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй” гэсэн оюутан нэлээд гарсан. Бид үүнд арга хэмжээ авлаа. Амьдралын түвшин доогуур, төлбөрийн чадвар муутай оюутанд төлбөрөө сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж авдаг л даа. Тэр боломжийг нь олгоод төлбөрөө өгөөгүй ч гэсэн бүртгэж байна. Ер нь сургалтын төлбөрийн төлөлтөд уян хатан хандаж байгаа. Мөн оюутны дотуур байрны төлбөрийг нэмээгүй. Дотуур байрны төлбөр сарын 40-45 мянга байдаг. Оюутнууд бүтэн хичээлийн жилд 10 сар дотуур байранд суудаг юм. Ингээд бодохоор 400-450 мянга болно. Манай сургууль долоон оюутны дотуур байртай. Манай сургуулийн засварын ажил дууссан. Одоогийн байдлаар цэвэрлэгээ, үйлчилгээний ажил хийгдэж байгаа. Оюутны байранд нэлээд их засвар хийгдсэн. Тухайлбал, хүчин чадлыг нь нэмэгдүүлж 50-60 оюутан шинээр нэмж авах боломжтой болсон. Манай сургууль оюутнуудаа хүлээж авахад бэлэн. Ер нь манай сургууль төрийн өмчийн сургуулиуд дундаа хамгийн бага төлбөртэй нь байх. МУИС, Анагаах, Боловсролын их сургуулиас бага төлбөртэй. Олон оюутантай учраас төлбөрийг нэмэх шаардлагагүй.

## Л.Ганцэцэг: Төлбөрийн нөхцөлийг уян хатан байлгах чиглэлийг барьж байна

*/МУБИС-ийн Эдийн засаг хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал/*



-Манай сургууль бакалвр, магистр, докторт суралцаж буй гадаад болон дотоодын 16 мянган оюутантай. Энэ жил сургалтын төлбөр нэмэгдээгүй. Нэгдүгээр курсийн сургалтын төлбөр дунджаар нэг сая 950 мянган төгрөг. Курс ахих тусам нэг сая 750 мянган төгрөгийн төлбөртэй болдог. Харин оюутны байр 384 мянган төгрөгийн үнэтэй. Манай сургууль нийт 3500 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай. Суралцахыг хүссэн бүх хүүхдийг бүрэн хамруулахгүй боломжтой. Энэ жил салбарын сайд “төлбөр битгий нэм” гэсэн чиглэл өгсөн учраас удирдах зөвлөлөөрөө төлбөрөөгүй нэмэхгүй байхаар шийдсэн. Манай сургуулийн ихэнх хүүхдүүд буцалтгүй тусламж, онооны хөнгөлөлтөөр суралцдаг. 650-аас дээш оноотой хүүхдүүд 30-100 хувийн төлбөрийн хөнгөлөлт эзэлдэг. Захирлын нэрэмжит тэтгэлэг гэж бий. Мөн сургалтын төрийн сангийн тэтгэлэгт хамрагддаг. Төлбөрийг семистерээр нь ав гэсэн чиглэл салбар яамнаас өгсөн. Төлбөрөө түрүүлж төлсөн оюутнууд “тал хувиа төлбөрөө авъя” гэж бидэнд хандаж байгаа. Төлбөр төлөлт 30 хувьтай байна. Энэ жил 3700 хүүхэд элсүүлж авах төлөвлөгөө бий. Манай сургууль жил бүр жижиг засварууд хийдэг. Засварын ажил дууссан. Энэ сарын 20-нд оюутнуудаа эмчийн үзлэгт оруулсан юм. Наймдугаар сарын 22-ноос оюутнуудаа авч эхэлсэн.

## Т.Хэрүүга: Сайдын “Их, дээд сургуулийн сургалтын төлбөрийг нэмэхгүй” гэсэн чиглэлийг барьж байна

*/Хөдөө аж, ахуйн их сургуулийн захирал/*



-Манай сургуулийн сургалтын төлбөр энэ жил нэмэгдээгүй. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд “Их, дээд сургууль сургалтын төлбөрөө нэмж болохгүй” гэсэн чиглэл өгсөн. Тийм учраас манай сургууль төлбөрөө нэмээгүй. Өнгөрсөн хичээлийн жил сургалтын төлбөр 1.5-2 сая төгрөг байсан. Сургалтын төлбөр курс, судлах кредит цагаасаа хамааран өөр өөр байдаг л даа. Тэгэхээр энэ жил өнгөрсөн жилийн сургалтын төлбөрөө авч байна. Манай сургуулийн хичээлийн бэлтгэл дууссан. Бүх засвар, үйлчилгээний ажил хийгдлээ. Одоо бүртгэл бас дуусч байна. Оюутны бүртгэлийн ажил 80 хувьтай явж байгаа. Мөн салбар яамнаас төлбөрийн уян хатан нөхцөлөөр ажиллах чиглэл өгсөн. Тиймээс төлбөрийн чадваргүй, үнэхээр төлбөрөө төлөх боломжгүй оюутнуудад зохих журмын дагуу арга хэмжээ авч байна. Аль болох тухайн хүүхдийг сургах чиглэлийг барьж байгаа.

## Я.Чойжамц: Сургалтын төлбөрөө нэмээгүй

*/Батлан хамгаалахын их сургуулийн захирал/*




-Манай сургуулийн сургалтын төлбөр курсээсээ хамаараад янз бүр. Энэ жил салбар яамнаас нэмэхгүй байх чиглэл өгсөн учраас нэмээгүй. Гэхдээ сургалтын төлбөрөө нэммээр байна. Нэмэхгүй болохоор сургалтын чанар муу л байна. Ганц ном худалдаж авч чадахаа болж байна. Автоматаар шууд нэмэх нь буруу. Ингэж механикаар шууд зохицуулдаггүй юм. хэрэгцээнээсээ хамаарах ёстой шүү дээ. Салбар яамнаас бичиг ирсэн болохоор нэмж чадахгүй л байна. Төр үүнд хутгалдахаар яаж их, дээд сургуулиуд хөгжих вэ дээ. Чанартай боловсон хүчин бэлтгэе гэвэл төлбөрөө нэмэх хэрэгтэй. Шинэ ном хэвлэл хүртэл худалдаж авах, интернэтийн төлбөрөө хүртэл төлмөөр байна. Тэгээд хуучин мэдээллээрээ л байдаг. Шинэ мэдээлэл ч авч чадахгүй. Тэгсэн хэрнээ дээд боловсрол эзэмшиж байна гэдэг. Манайд үндэсний дээд сургуулиудын төлбөр үнэн инээдэмтэй байна. хувийн дунд сургуулийг хар л даа. Жилийн төлбөр нь 40-60 мянган ам.доллар. Хобби сургууль 8-10 сая төгрөг гэж байхад мэргэжил олгож байгаа их, дээд сургуулийн төлбөр 2-3 сая төгрөг л байна шүү дээ. Манай сургуулийн төлбөр нэг сая 200 мянгаас нэг сая 800 мянга байдаг.

## Г.Ганбаяр: Нэг кредитийн төлбөр 65.500 төгрөгийн үнэтэй

*/Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн эдийн засагч/*




-Манай сургуулийн 2016-2017 оны сургалтын төлбөр нэмэгдээгүй. Өнгөрсөн хичээлийн жилд авсан төлбөрөө авч байгаа. Хичээлийн нэг кредит нь 65.500 төгрөгийн үнэтэй. Бусад сургууль курсээсээ хамаараад өөр өөр төлбөртэй байдаг. Манай сургуулийн хувьд курс харгалзахгүйгээр кредит цагийн үнэ ижил байдаг. Өөрөөр хэлбэл, бүх курсийн оюутны судлах хичээлийн кредит цагийн үнэ ижил гэсэн үг. Манай сургууль дотуур байртай. Дотуур байрны төлбөр 500 мянган төгрөг байгаа. Засварын ажил хийгдэж байна. Хараахан дуусаагүй. Гэхдээ хичээл эхлэхээс өмнө амжиж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Төлбөрийн хувьд хувааж төлнө гэсэн зүйл байхгүй.

## О.Янжмаа: Сургалтын төлбөр нэг сая 800 мянга хэвээрээ байгаа

*/Дорнод их сургуулийн захирал/*




-Манай сургуулийн төлбөр энэ жил нэмэгдээгүй. Сүүлийн хоёр жил огт нэмээгүй. Нэг сая 400 мянга байсан. Энэ жил нэг сая 850 мянга болсон. Гэхдээ энэ нь тодорхой учир шалтгаантай. Өнгөрсөн жилийн тавдугаар сард нэг сая 850 мянга болж нэмэгдсэн юм. 2015 онд манай сургууль зэрэглэлээ ахиулж, их сургууль болсон. Судалгааны ажилтантай болох, оюутнуудаа судалгааны ажилд хамруулах, лабораторитой болохын тулд оюутнуудтай хурал хийгээд ингэж шийдсэн. Тэгэхээр өнгөрсөн жилийн тавдугаар сард нэг сая 850 мянга болсон. Энэ жил ч гэсэн мөн адил байна. Сургалтын төлбөрийг огт нэмээгүй. Мөн дотуур байрны мөнгө ч нэмэгдээгүй. 400 мянга хэвээрээ байгаа. Энэ жил элсэлтийн шалгалтын оноогоороо тэнцэн, албан ёсоор орсон элсэгч 80 бүртгүүлсэн. Үүнээс гадна манай сургуульд гадаадын 44 хүүхэд нэмж суралцахаар болоод байна. Дотуур байр, сургуулийн засвар ерөнхийдөө хийгдэж дууслаа. Одоо бид хашаагаа будаж байна. Оюутнуудаа бүртгэж авахад бэлэн болсон.

## ДЭЛХИЙ

### Францыг зорих жуулчдын тоо долоон хувиар буурчээ

Францын Гадаад хэргийн сайд тус улсыг зорих жуулчдын тоо энэ он гарсаар долоон хувиар буурсан үзүүлэлттэй байгаа тухай мэдээллээ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр жуулчдын тоо ийн буурах болсон нь хэт даврагчдын террорист халдлага, цаг агаарын байдал, нисэх хүчнийхний ажил хаялт зэрэгтэй холбоотой аж. Аялал жуулчлал буурсантай холбоотойгоор зарим аж ахуй нэгжүүдийн орлого ч буурчээ. Тодруулбал, зөвхөн Парист гэхэд л зочид буудлын нэг хоногийн төлбөр 11.4 хувиар буурч, энэ салбарын орлого нь нэг тэрбум еврогоор буурсан байна. Францын Үндэсний статистикийн газрын мэдэгдсэнээр, тус улсыг зорих жуулчдын тоо зургадугаар сард эрс буурсан байна. Ажиглагчдын үзэж буйгаар, жуулчдын тоо буурсан нь зургадугаар сарын 10-наас долдугаар сарын 10-нд Францад хөлбөмбөгийн Европын АШТ зохион байгуулсантай холбоотой ажээ. Францад өнгөрсөн онд олон хүний аминд хүрсэн террорист халдлага нэг бус удаа болсон билээ. Тухайлбал, арваннэгдүгээр сард нийслэл Парис хотод 130 хүний аминд хүрсэн цуврал халдлага болсон бол зургадугаар сард Ницца хотод ачааны машинтай этгээд олон хүн цугласан талбай руу дайран орж, 84 хүний аминд хүрсэн юм.

# ИТАЛИЙН НЭГ ХОТ ГАЗРЫН ХӨРСНӨӨС АРЧИГДАХ ШАХАВ

–Италичууд бүхэлдээ шокийн байдалд байна–



Б.ДАВААХҮҮ

Италийн төв хэсэгт өчигдөр орон нутгийн цагаар 03.30 цагт 6.2 магнитудын хүчтэй газар хөдөллөө. Гэнэтийн энэхүү байгалийн гамшигт үзэгдлийн улмаас Аматрис гэх жижиг хот сүйрлийн ирмэгт тулав. Хотын олон тооны байшин барилга нурж сүйдсэнээс гадна эрдэнэт хүний амь үрэгдэж, тосгоны тал хувь нь сүйдлээ гэх мэдэгдлийг хотын дарга нь дэлхий дахинаа зарлалаа. Хотын дарга, хотын иргэд гээд итали бүхэлдээ шоконд оржээ. 20 орчим секундын хүчтэй чичиргээнд нэг тосгоны тал нь иргэдийн нүдэн дээр сүйдсэн тул тухайн бүс нутгийн иргэд шоконд орохоос ч аргагүй. Дугаар шилжих мөчид авсан хамгийн сүүлийн мэдээллээр газар хөдлөлтийн гамшгийн улмаас амиа алдсан хүний тоо 13 болж нэмэгдсэн байв. Гэхдээ хохирогчдын тоо цаашид ч нэмэгдэж магадгүй байна. Зөвхөн Аматрис хот ч бус. Газар хөдлөлтийн голомтын ойролцоо байрлах бүх л уулын хотуудад ийм дүр зураг ажиглагджээ. Тосгоны иргэд гудамжинд гарч, цахилгаан тасарч, зам харилцаа сүйдсэн байна. Аматрис хотын захирагч Сергио Пироззи хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Хот үгүй болсон. Иргэд нурсан барилгын дор оршуулагдчихлаа” хэмээн халаглан ярьжээ. Аматрис хот Италидаа нэлээд алдартай. Уулархаг бүс нутагт орших байгалийн үзэсгэлэн бүрдсэн энэ хотод уулын цэвэр агаараар амьсгалахаар зуны дунд сард ромчууд олноороо ирдэг аж. Гэвч зуны аялал жуулчлалын оргил үед ийнхүү байгалийн гамшигт үзэгдэл болсон байна.

> ...Харин Норсиа хотын хувьд хохирлын хэмжээ харьцангуй бага байгаа юм байна. Тэнд одоогоор хүний амь эрсдсэн гэсэн мэдээлэл байхгүй байгааг хотын захирагч нь мэдээлжээ...

Газар хөдлөлтийн голомт Умбриа мужийн Норсиа хотоос ойролцоогоор 10 км-ын зайд байсан бөгөөд гүн нь 10 км-т байсан тухай АНУ-ын Геологийн судалгааны хүрээлэнгээс мэдээлсэн. Хохирлын хэмжээг тооцоолоход эдүгээ эрт байгаа ч, Умбриа, Лазио, Марче гэсэн гурван бүс нутаг хамгийн их хохирол амсчээ. Байшин барилга нурж, харилцаа холбоо тасарсан учир төсөөлж байгаагаас ч илүү олон хүн амь үрэгдсэн байх магадлалтай гэнэ. Газар хөдлөлт оршин суугчдыг унтаж байх үед болж, иргэд бүгд гудамжинд гүйн гарсан байна. Улмаар үүр хаяарч эхлэмэгц бульдозер, экскаватор машинуудыг ашиглан хаагдсан замуудыг нээж, нурсан барилга дороос амьд хүн хайх эрлийн ажиллагааг эхлүүлжээ. Гэвч харамсалтай нь нуранги дор амьд хүн байх магадлал тун бага аж. Марче бүс нутгийн Пескара дел Тронто дахь байшингийн нуранги дороос ахимаг насны хосуудын цогцос олдсон бол Аматрис хотын барилгын нуранги дороос ч мөн хоёр цогцос олджээ. Хотын эмнэлгийн барилга ч нурж, өвчтөнгүүд нь ч гудамжинд гарсан тухай орон нутгийн мэдээллийн агентлагууд дамжуулж байна. Уулын Аккумоли хотод ч хүний амь эрсэджээ. Газар хөдлөлтийн голомттой ойролцоо байрлах Аккумоли хотын захирагч Стефано Петрусси нөхцөл байдал төсөөлснөөс ч муу байна хэмээн хэвлэлд ярьсан байв. Тэрбээр “Үүр хаяармагц бид эхлээд нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. Байшин барилга нурж байдал төсөөлснөөс ч илүү аймшигтай байлаа. Хүмүүс барилгын нурангид дарагдсан. Амьд үлдсэн байх найдвар тун бага байна” гэсэн байна. Энэ бүс нутагт гэр бүлийн дөрвөн хүн байшингийнхаа нуранги дор үүрд нойрссоны хоёр нь бага насны хүүхэд байжээ.

Харин Норсиа хотын хувьд хохирлын хэмжээ харьцангуй бага байгаа юм байна. Тэнд одоогоор хүний амь эрсэдсэн гэсэн мэдээлэл байхгүй байгааг хотын захирагч нь мэдээлжээ. Норсиа хотын хувьд аялал жуулчлалаараа алдартай бөгөөд түүхэн дурсгалт барилгууд олон байдаг юм.

Умбриа мужийн Сисели хотын иргэн Лина “Маш хүчтэй чичиргээн мэдрэгдсэн. Бид өрөөн дотроо ортойгоо явж байсан” хэмээн ярьсан байна. Ерөнхий сайд Матью Рензигийн хэвлэлийн албанаас мэдээлснээр тус улсын Засгийн газар иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, мэдээлэл солилцож байгаа гэнэ. Газар хөдлөлт болсноос хойш гурван цагийн дараа түлхэлт мөн болжээ. Түлхэлтийн хүч нь 5.5 магнитуд байсан аж. Газар хөдлөлтийн голомтоос 150 орчим км зайд орших Ромд ч чичиргээн мэдрэгдэж, шөнө дунд унтаж байсан оршин суугчид бүгд сэрсэн гэсэн мэдээлэл байна. Гэхдээ азаар хүний амь эрсдсэн мэдээлэл алга.

Италид өмнө нь долоон жилийн өмнө өчигдрийнх шиг маш хүчтэй газар хөдлөлт болж байв. 2009 оны дөрөвдүгээр сарын 6-нд Л’Акила хотын ойролцоо 6.3 магнитудын хүчтэй газар хөдөлж, дэд бүтэц сүйрч байсан юм. Тухайн үед 300 гаруй хүн амиа алдаж, мянга орчим хүн гэмтэж бэртжээ. Харин зургаан эрдэмтэн, Засгийн газрын нэг алба хаагч газар хөдлөлт, болзошгүй аюулын тухай буруу зөвлөмж өгсний улмаас чанга дэглэмтэй хорих ангид зургаан жилийн өнгөрүүлэх ял сонсч байсан удаатай. Мөн 2012 оны тавдугаар сард Ромагна бүс нутгийн Эмилиагийн хойд хэсэгт газар хөдөлж, 23 хүн харамсалтайгаар амиа алдаж, 1400 гаруй хүн орох оронгүй болон гудамжинд гарч байв.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 08-р сарын 25-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** г-2016 онд Налайх дүүргийн Дулаааны станцад технологийн нүүрс нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** г- Д/ҮТН-2016-2

**Налайх дүүргийн Дулааны станц нь** эрх бүхий тендерт оролцогчдоос **“г-2016 онд Налайх дүүргийн Дулааны станцад технологийн нүүрс”**–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг,** эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.
Төлбөрийг бэлнээр тушаана.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2014, 2015 хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын нийлбэр нь Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 20 хувиас дээш байна.
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас багагүй.
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жилийн /2014, 2015/ оны санхүүгийн тайлан ирүүлнэ.
**Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Ирүүлнэ.
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Шаардлагатай
Тендерийн хамт 6 000 000 (зургаан сая төгрөг )төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг **2016 оны 09 сарын 26 -ны өдрийн 11:00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2015 оны 09 сарын 26 -ны өдрийн 11 цаг 40 минутанд** нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: “Тооцохгүй”
Дотоодны давуу эрх тооцох эсэх: “Тооцохгүй”
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, Найрамдлын гудамж Налайх дүүргийн Дулааны станц**
**Утас: 70232356., 99147145**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдөр
Гэрээний нэр , дугаар: Багануур ХК-д харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх, СШУ № БНХК 2016-04-01

1. “Багануур” ХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг Багануур ХК-д харуул, хамгаалалтын ажил үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендерийн баримт бичиг /болон нэмэлт хувь/-ийн иж бүрдэл бүрийг нь албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 100000 /нэг зуун мянган/ төгрөгөөр Худалдаа хөгжлийн банкны 499031495 тоот дансанд тушаан худалдан авах боломжтой.
3. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба тендерийн үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн тендерийн баталгаа хамт ирүүлнэ.
4. Тендерийг 2016 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн 09 цаг 30 минутаас өмнө доорхи хаягаар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минутад нээнэ.

Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр, ажлын цагаар хаяг № 1-ээс худалдан авах ба тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг № 2-оос авч болно.
Хаяг № 1 : Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Р.Энхбаатар Утас 70157719, 99098715, 99023137 Факс 70157719
Хаяг № 2 : Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3 хороо Үйлдвэр хэсэг Багануур ХК-ийн байр 309 тоот өрөө ӨТХ-н инженер Г.Хасбаатар Утас: 7021-0310 Дотуур утас-1051


### Пхеньян баллистик пуужин харвалаа




АНУ, БНСУ-ын хамтарсан цэргийн сургуулилт энэ сарын 22-ны өдөр эхэлсэн. Жил бүр хоёр долоо хоногийн хугацаатайгаар АНУ, БНСУ-ын цэргийнхний хамтарсан сургуулилт болдог бөгөөд энэ удаа Сөүлийн талаас 50 мянга орчим, АНУ-аас 25 мянган цэрэг оролцож байгаа юм. Гэвч хоёр улсын цэргийн сургуулилтыг БНАСАУ-ын зүгээс удаа дараа эсэргүүцэж буйгаа илэрхийлэн хариу цохилт үзүүлнэ гэдгээ анхааруулсан.

Жил бүр тус цэргийн сургуулилттай зэрэгцэн Өмнөд болон Хойд Солонгосын зөрчил хурцаддаг ч, энэ жил БНАСАУ-ын өндөр албан тушаалтан Сөүлд орогносон тул сүрдүүлэг биелэх олж болзошгүй зарим эх сурвалж анхааруулж байсан юм. Тэгвэл Пхеньян өчигдөр Япон тэнгисийн зүг баллистик пуужин харваж, Сөүлд сануулга өглөө. Тэд шумбагч онгоцноос харвах систем бүхий SLBM загварын баллистик пуужин харвасан бөгөөд цөмийн мэргэжилтнүүд БНАСАУ-ын пуужингийн хөгжүүлэлт амжилтад хүрснийг онцолж байна. Пуужин 500 км-т тусчээ.

### Гюленыг Туркт шилжүүлнэ

Өнгөрсөн сард цэргийн эргэлт хийх оролдлогыг зохион байгуулсан гэж сэжиглэгдэж буй Феттулла Гюленыг шилжүүлэн өгөх хүсэлтийг Анкарагаас албан ёсоор хүлээн авснаа АНУ-ын Төрийн департамент мэдэгдлээ. Төрийн департаментын хэвлэлийн төлөөлөгч Марк Тонер мягмар гарагт сэтгүүлчдэд мэдэгдэл хийхдээ “Гюленыг шилжүүлэн өгөх хүсэлтийг бид Туркээс албан ёсоор хүлээн авсан” гэв. Долдугаар сарын 15-нд цэргийн эргэлт хийхийг оролдсон Туркийн армийн доторх цөөнхийн бүлгийг лалын шашны номлогч, Америкт байгаа Гюленаас заавarчилгаа авсан гэж Туркийн эрх баригчид үзэж байгаа юм. Цэргийн эргэлт хийхийг оролдох явцад 240 хүн амь үрэгдэж, бараг 2200 хүн шархадсан билээ. АНУ-ын дэд Ерөнхийлөгч Жо Байдены Туркэд хийх айлчлалын өмнөх өдөр Тонер ийм мэдэгдэл хийлээ.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Газар тариалангийн бүс нутагт цочир хүйтэрнэ

ОБЕГ-аас хадлан бэлчээр, өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг уурын нөхцөл байдал болон бусад асуудлаар мэдээлэл хийлээ. Энэ жил бороо хур элбэгтэй байгаа боловч газар тариалангийн бүс нутагт ургац, хадлан авах хугацаа оройтож, тариа болон хүнсний ногооны болц оройтож болзошгүйг ОБЕГ-аас мэдээллээ. Тиймээс хөдөө аж, ахуйн бүсүүд дараах арга хэмжээг авах шаардлагатай байгааг анхааруулжээ. Тухайлбал, Газар тариалангийн бүс нутгийн хувьд наймдугаар сарын сүүлийн арван хоног болон есдүгээр сарын дунд үеэс цочир хүйтэрч хяруу унах төлөвтэй байгаа учраас хяруунаас хамгаалах зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулахыг анхааруулсан юм. Мөн тариа будааг цасанд даруулахгүйн тулд зохистой арга хэмжээг авч, ангилан хадах үйл ажиллагааг цаг тухайд нь хийх шаардлагатай гэдгийг санууллаа.

## Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг гинзгийрүүлэн сургана

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд "Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын гүнзгийрүүлэх шатны сургалт зохион байгуулах тухай" А/609 дүгээр захирамж гаргажээ. Захирамжийн дагуу Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлагыг гүнзгийрүүлэх шатны сургалтыг 2016 оны есдүгээр сарын 21-нээс аравдугаар сарын 03-ны өдрүүдэд хуваарилан зохион байгуулах гэнэ. Тухайлбал, нэгдүгээр хэсэгт, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, хоёрдугаар хэсэгт, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг, гуравдугаар хэсэгт, Налайх, Багануур, Багахангай дүүрэгт зохион байгуулах юм байна. Харин сургалтын нэгдүгээр хэсгийг Баянгол дүүргийн Засаг даргын ТамгынгазрынЦэргийнштабын дарга, хурандаа Л.Ганбаатар, хоёрдугаар хэсгийг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Л.Батаа, гуравдугаар хэсгийг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа В.Батболд нар тус тус хариуцан ажиллах юм.

## Тээврийн бүртгэлийн үйлчилгээ түр хугацаагаар шилжив

"АСА Цирк"-ийн гадна талбай болон дотор хэсэгт дулааны болон усны шугам солих зэрэг засварын ажил хийгдэж байгаа юм. Тиймээс тус төвд байрлах тээврийн бүртгэлийн үйлчилгээ энэ сарын 24, 25, 26-ны өдрүүдэд түр хугацаагаар ажиллахгүй аж. Засварын ажил дуустал иргэд дараах газруудаас тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой бүхий л үйлчилгээг авах боломжтой. Тодруулбал, БГД 20-р хороо "Хөсөг трейд" ХХК-ийн байр, БЗД 8-р хороо Улаанхуаран хилчний 1-р гудамж, "Таван ган" ХХК-ийн байр, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Авто худалдааны цогцолбор, БЗД 17-р хороо, "Да Хүрээ" худалдааны төвд шилжсэн аж.

### ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

-Дондог овогтой Доржийн /рдФЖ44111018/ иргэний үнэмлэх 170123дугаартай тэтгэврийн дэвтэр

-Балдан овогтой Цэнд-Аюушийн ХУД-ийн 8-р хорооны нутаг дэвсгэрт 379.5 м2 талбайтай, 5009400 төгрөгний үнэтэй газрын үнэгүй өмчлүүлэхээр шийдвэрлэсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай НЗД-н 2003 оны 362-р захирамжтай шийдвэрийг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

# Я.СОРОНЗОНБОЛД: ХҮҮХДИЙН АВТОБУСАНД ШАЛГАЛТ ХИЙНЭ

Н.БАТЗАЯА

*Оюутан сурагчдын хичээл эхлэхэд долоо хоногийн хугацаа үлдсэн. Үүнтэй зэрэгцээд хөдөө орон нутгаас нийслэлийг зорьсон замын хөдөлгөөн нэмэгддэг. Тиймээс Улаанбаатар Замын цагдаагийн газрын ахмад Замын Цагдаагийн газрын УСОНХХ-ийн цагдаагийн мэргэжилтэн, ахмад Я.Соронзонболдоос зарим зүйлийг тодрууллаа.*

**-Зам тээврийн осол өдөр бүр гарч байна. Саяхан гэхэд Зунжингийн замд их том осол гарлаа шүү дээ. Энэ зун хэчнээн зам тээврийн осол гарсан бэ?**

-Улаанбаатар хотын Замын цагдаагийн газарт эхний долоон сарын байдлаар нийт 47 мянган зам тээврийн ослын дуудлага бүртгэгдлээ. Үүнээс зам тээврийн гэмт хэрэгтэй холбоотой 1027 дуудлага хүлээн авсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.8 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Өнгөрсөн жилийн эхний долоон сарын байдлаар нийт 1250 дуудлага бүртгэгдсэн. Мөн зам тээврийн гэмт хэргийн улмаас 708 хүн хүнд, хөнгөн гэмтсэн байна. Энэ нь өнгөрсөн оны долдугаар сартай харьцуулахад 11.8 хувиар буурсан байгаа юм. Харин зам тээврийн ослоор нийт 198 хүн нас барсны дийлэнх нь буюу 144 нь орон нутгийн замд гарсан ослын улмаас амиа алдсан. Үүний 28 нь бага насны хүүхэд байна. Нийт нас барсан хүүхдийн 24 нь мөн л орон нутгийн замд амиа алдсан. Ер нь нийт бүргэгдсэн 47 мянган дуудлагыг харахад дийлэнх нь нийслэлд гарсан байдаг. Учир нь эд материалын хохиролтой осол их гардаг юм. Харин зам тээврийн ослын улмаас нас барсан хэрэг хөдөө орон нутагт их гардаг. Нас барсан тохиолдлын ихэнх нь хөдөө орон нутгийн замд гарсан осол байдаг. Орон нутгийн замд нас баралт ихсэж байгаа нь нөгөө л замын нөхцөлд хурдаа тохируулж яваагүй, хэт ядарсан үедээ автомашин жолоодож яваад нойрмоглодог, гүйцэж түрүүлэх үйлдэл хийхдээ өөдөөс ирж байгаа тээврийн хурдыг тооцоолоогүйтэй холбоотой. Мөн жолооч нар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодож байгаад олон хүний амийг хохироодог. Орон нутгийн замд гарсан ослын дийлэнх нь онхолдсон байдаг.

**-Оюутан, сурагчдын хичээл орж буйтай холбогдуулан орон нутгийн замд шалгалт хийж байгаа гэсэн. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Замын цагдаагийн газраас хичээлийн жил эхлэхтэй холбоотой хэд хэдэн ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тэдгээр ажлын нэг нь "Оюутан тээвэр" шалгалт юм. Наймдугаар сарын 21-нд хяналт, шалгалтын ажлыг эхэлсэн. Шалгалт есдүгээр сарын 5 хүртэл үргэлжилнэ. Энэхүү ажлыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтарч зохион байгуулж байна. Шалгалтыг нийслэлээс гадагш орон нутаг руу чиглэсэн гурван постон дээр хийж байгаа. Тухайлбал, Төв аймгийн Лүн сум, зүүн чиглэлийн замд буюу Чонжинболдогийн тэнд, хойд чиглэл буюу Дархан, Сэлэнгийн замд 24 цагийн хөдөлгөөнт шалгалт хийгээд эхэлсэн. "Оюутан тээвэр" хяналт, шалгалтын ажлыг жил бүрийн хавар болон намрын улиралд хийдэг. Намар оюутнуудын хичээл эхэлдэг учраас нийслэлийг чиглэсэн замын хөдөлгөөн ихэсдэг. Энэ үеэр хүн тээвэрлэх, ачаа тээвэрлэх журмыг зөрчих тохиолдол гардаг. Мөн хулгайн тээврийн асуудал яригддаг. Насжилт нь дууссан, бүрэн бус тээврийн хэрэгслээр эсвэл согтуугаар хүн тээвэрлэдэг. Жолоочийн үнэмлэхгүй байж, хүн тээвэрлэж байгаад осол гарган хүний амийг хохироох асуудал гардаг учраас "Оюутан тээвэр" шалгалтыг зохион байгуулдаг. Мөн есдүгээр сарын 1-нтэй холбоотойгоор энэ сарын 25, 26-нд Дүнжингарав төв дээр нийслэлийн хэмжээн дэх

...Урьд нь хүүхдүүдийн цүнхэн дээр цацруулагч хийж өгсөн. Тэр цацруулагч зөвхөн орой гэрэлтэх үүрэгтэй. Харин баруун гарын цацруулагч нь өглөө, өдөр, шөнө гэрэлтдэг. Хүүхдүүд ханцуйвчаа баруун гартаа өмсч, замын хөдөлгөөнд оролцохдоо баруун гараа өргөх юм...

хүүхдийн автобусанд шалгалт хийхээр төлөвлөөд байна. Хүүхдийн автобусанд тавигдах MNS:64442014 гэсэн стандарт бий. Тэр стандартын дагуу насжилт нь хэтэрсэн үү, техник бүрэн аюулгүй байна уу, суудлын тоо нь ямар байна гэх мэтчилэн зүйлд хяналт тавьж ажиллана. Энэхүү ажлыг Нийслэлийн тээврийн газар, Боловсролын газартай хамтарч зохион байгуулахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар дүүрэг болон сургуулийн хүүхдийн автобусны материалыг хүлээж авч байгаа.

**-Нийтийн тээвэрт явж байгаа автобусаар ч гэсэн бага насны хүүхэд үйлчлүүлдэг шүү дээ. Тэгэхээр нийтийн тээвэрт ч гэсэн шалгалт хийнэ гэсэн үг үү?**

-Үгүй. Нийтийн тээврийн автобусанд шалгалт хийхгүй. Учир нь нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа автобус жилд хоёр удаа оношлогоонд ордог. Шаардлагатай тохиолдолд гурван ч удаа оруулдаг. Нийтийн тээвэрт хяналт тавьдаг байгууллагууд бий. Өглөө бүр тухайн жолооч согтуу байна уу, техник нь бүрэн бүтэн үү гэдэгт хяналт тавьдаг хүмүүс байдаг тул шалгалт хийхгүй. Зөвхөн хүүхэд тээвэрлэдэг автобусанд л шалгалт хийнэ. Мөн Замын цагдаагийн газар Монголын сурагчдын холбоотой хамтран сурагчдыг баруун гарын цацруулагчтай болгох ажлыг эхлүүлэхээр болсон. Сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэдэг "Батзүү", "Шилмэл загвар", "Төмөр трейд", "Өүлэн менч", "Скайтел", "Доктор авто сервис" зэрэг компанитай хамтран гэрэл цацруулагчтай ханцуйвч хийж бага насны хүүхдүүдэд тараана. Урьд нь хүүхдүүдийн цүнхэн дээр цацруулагч хийж өгсөн. Тэр цацруулагч зөвхөн орой гэрэлтэх үүрэгтэй. Харин баруун гарын цацруулагч нь өглөө, өдөр, шөнө гэрэлтдэг. Хүүхдүүд ханцуйвчаа баруун гартаа өмсч, замын хөдөлгөөнд оролцохдоо баруун гараа өргөх юм. Ингэснээр өөрийн аюулгүй байдлыг хангана. Уг ажил нь "Хэрвээ би замын хөдөлгөөнд оролцохдоо баруун гараа өргөж оролцохгүй бол жолооч надад зам тавьж өгөхгүй. Би зам тээврийн осолд өртөнө" гэдэг ухамсрыг л хүүхэд бүрт суулгах зорилготой. Ер нь 10 хүртэлх насны хүүхдийг бие дааж замын хөдөлгөөнд оролцохыг хориглосон шүү дээ.

**-Тараах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ?**

-Эхний удаа 20-30 мянган ширхэг ханцуйвчийг үнэгүй тараана. Дараагийн удаа хэвшээд ирэхээр нь эцэг, эхчүүд өөрсдөө авна. Эхний удаа үнэгүй авчихаад хаясан бол дараа нь өөрсдөө худалдаж авах юм. Ямар ч байсан эхний удаа хийлгэх нь чухал. Хийсний дараа тараах учиртай. Хэрвээ тараах бол багш нарт нь хүүхдийнх нь тоогоор өгөх үү, эсвэл сурагч бүрт өөрт нь хариуцуулж өгөх үү гэдгийг тухайн үед шийднэ. Мөн бид нэгдүгээр курст орж байгаа оюутан болон бага ангийн хүүхдүүдэд "Замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй оролцох вэ" сэдэвт хичээл заахаар төлөвлөөд байна.

# Эрэн хайх авран туслах албадын хамтарсан сургуулилт эхэллээ










Монгол Улс, ОХУ-ын эрэн хайх, авран туслах албадын дөрөв дэх удаагийн хамтарсан сургуулилт-SAREX-2016 Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр Элсэн тасархайд өчигдөр эхэллээ.

Иргэний агаарын хөлгийн осол, сүйрлийн үед аюулд нэрвэгдсэн хүмүүст шуурхай тусламж үзүүлэх чиглэлээр хөрш зэргэлдээ орнуудтай эрэн хайх, авран туслах албадын хамтын ажиллагааг бий болгох үүднээс манай улс ОХУ-тай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж, хамтарсан сургуулилтыг дөрөв дэх удаагаа хийж байна. Анхны хамтарсан сургуулилтыг 2010 онд ОХУ-д хийснээс хойш талууд хоёр жил тутамд ээлжлэн зохион байгуулж байгаа бөгөөд манай улс анх 2012 онд Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны нутаг дэвсгэрт хамтарсан сургуулилтыг амжилттай хийсэн юм. Энэхүү сургуулилтын үйл ажиллагааг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл, ИНЕГ-ын дарга Г.Нямдаваа, ОХУ-ын ХАТА-ийн орлогч дарга А.В.Ведерников нар нээж, үг хэлэв.

Монгол Улсын Засгийн газар агаарын тээврийн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэгд тооцож, иргэний нисэхийг даяаршлагдсан дэлхийн иргэний агаарын тээврийн нэгэн бүрдэл болгох, бүс нутагтаа тэргүүлэх орнуудын хэмжээнд хөгжүүлэх зорилт тавьж байгааг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл нээлтийн эхэнд онцлон хэллээ. Тэрээр энэ салбарын хөгжлийг хангах бодлого стратегийг авч үзэхдээ иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандартад нийцсэн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангах, энэ чиглэлээр олон улсын дэвшилтэт арга ажиллагаа, сайн туршлагыг судлан хэрэгжүүлэхийг бодлогын салшгүй нэг хэсэг болгон дэмжихээ илэрхийллээ. Энэхүү сургуулилтыг говь, хангай хослосон элсэрхэг газар зохион байгуулагдаж байгаа нь нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд дахин нэг шинэ сорилт, шинэ дадлага, туршлагыг бий болгож, байгаль орчны ямар ч нөхцөл байдалд тохируулан шуурхай, оновчтой шийдвэр гаргаж сурахад амжилттай дадлага, сургуулилт болох ач холбогдолтойг хэлсэн юм.

Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд террорист бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхижиж, иргэний нисэхийн эсрэг хууль бус үйл ажиллагаанууд удаа дараалан гарч, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах асуудалд дэлхий дахинаараа онцгой анхаарал хандуулж буй өнөө үед Монгол Улс өөрийн нутаг дээр аюулд нэрвэгдсэн агаарын хөлөгт бүхий л боломжоор тусламж үзүүлэх, бусад орнуудад эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд оролцох боломж олгох үүргээ зохих ёсоор биелүүлэхийг зорьж байгаа гэдгийг дэд сайд Б.Цогтгэрэл цохон дурдлаа.

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нямдаваа "SAREX-2016" сургуулилтын үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ "Энэ удаагийн дөрөвдүгээр хамтарсан сургуулилт говь, хангай хосолсон элсэрхэг бүс нутагт зохион байгуулагдаж байгаагаараа онцлог бөгөөд нийт 126 хүний бие бүрэлдэхүүнийг хамарсан томоохон хэмжээний сургуулилт хийж байгаа нь хоёр улсын Засгийн газар энэхүү хээрийн сургуулилтад ихээхэн ач холбогдол өгч байгаагийн илрэл" хэмээн онцлов.

Онцгой байдал үүссэн тохиолдолд хэрхэн үр дүнтэй, шуурхай ажиллах боломж бий болгох, байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах чухал ач холбогдолтой энэхүү сургуулилтад хойд хөршийн талаас ОХУ-ын ХАТА-ийн орлогч дарга А.В.Ведерников тэргүүтэй Ми-8 агаарын хөлөг бүхий 22 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож байна. Манай талаас ЗТХЯ, ЭМЯ, ИНЕГ, НТОЗШША, ОБЕГ, ЦЕГ, ЗХЖШ, ХХЕГ, ГИХГ, ГЕГ, МХЕГ, ТЕГ зэрэг байгууллагын 104 хүн оролцож байна.

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +19
Шөнө +5

Нөгөөдөр
Өдөр +22
Шөнө +7

## Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 08-р сарын 25, Пүрэв гараг*

**Билгийн тооллын:**
*Намрын тэргүүн улаан бичин сарын шинийн 23. Дөрвөн ногоон мэнгэтэй Шарагчин туулай өдөр. Бархасбадь гараг*

**Наран ургах/шингэх:**
*07:03 / 20:47*

**Үс засуулбал:**
*Эд эдлэл, идээ ундаа элбэг олдоно.*



Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, лусыг тахих, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сэтгэлд сэвтэй газар очих, газар хагалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиаболой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

# ÄÝËÕÈÉÃ ÑÈÐÈ Ð¯¯ ×ÈÃË¯¯ËÑÝÍ ÇÓÐÀÃ




Б.ДАВАА

“Үнэнийг хэлэхэд би хэзээ ч шокийн байдалд орсон Омран шиг хүүтэй таарч байсангүй. Түүнтэй ижил байдалд орсон хүүхдүүд ихэнхдээ, орилж хашгиран уйлдаг”. Энэ үгийг бидний өнөөдрийн “Дэлхийн шилдэг зураг” булангаараа уншигч танд хүргэж буй дээрх зургийг авсан Мустафа ал Сарут гэх зурагчин эр хэлжээ. Оросын цэргийнхэн Сирийн Алеппо хотод агаараас цохилт өгсний дараа байшингийнхаа нуранги дороос азаар аврагдсан ч, юу ч хэлэх тэнхэлгүй болтлоо шоконд орж, цус тоосонд дарагдан эмнэлгийн тусламж авахаар хүлээж суугаа Омран Дакнеш хүү яагаад ч юм зурагчны сэтгэлийн чанад дахь нарийн утсыг хөндөж чадсан тул өөрийн эрхгүй л камераа гарган зургийг нь дарсан гэх. Тэгвэл эдүгээ энэ зураг дэлхийн хамгийн олон орны хэвлэлд нийтлэгдэж, нийгмийн сүлжээнд хамгийн их тарж олон хүний сэтгэлд хүрч чаджээ. Мустафа ал Сарут бол Алеппог агаараас бөмбөгдсөний дараа мэргэжлийн ажлаа хийж явсан цөөн хэдэн гэрэл зурагчдын нэг байлаа. Гэхдээ түүний “boy in the ambulance” гэх энэ зураг таван жил үргэлжилсэн сирийн иргэний дайн руу дэлхий нийтийн анхаарлыг хандуулж чадсан нь хамгийн том амжилт байв. Сарут “Орон нутгийн аврах ажилтнуудын ашигладаг чанга яригчийн дууг сонсоод би гүйж очсон. Тэнд маш олон нас барсан хүмүүс. Бас газарт хэвтэн ёолох маш олон шархадсан хүмүүс байсан. Гэтэл нэг хүү л нуранги дороос аврагдсан хэдий ч чив чимээгүй суух нь миний анхаарлыг татсан юм. Тэр юу ч хэлэхгүй. Шоконд орчихсон байсан. Орилох ч үгүй. Хэн нэгнийг дуудах ч үгүй гараараа цусаа арчиж байсан. Түүний хувьд цус, бөмбөгдөлт ердийн л зүйл. Түүний амьдрал дэлхийн бусад хүүхдүүдийнхээс тэс өөр. Тэр гадагш гарч, тоглож чадахгүй. Тэр цус хараад уйлж бас гомдоллодоггүй. Яагаад гэвэл Омран өдөр бүр л иймзүйлтэй нүүр тулдаг шүү дээ” хэмээн ярьсан байна. Зураг дээрх тавхан настай энэ хүү гэртээ сууж байгаад л гэр бүлийнхнийхээ хамт бөмбөгдөлтөд өртжээ. Азаар эцэг эх нь амьд үлдсэн ч, 10 настай ах Али нь шархаа дийлэлгүй амьсгал хураасан байна. Эцэс төгсгөлгүй үргэлжилж буй Сирийн иргэний дайны гэм зэмгүй хохирогч бяцхан хүүхдүүдийн зөвхөн нэг жишээ нь л Омран хүү. Тиймээс ч энэ зураг нийгмийн сүлжээнд цацагдсан даруйд хүүхдийн эрхийг хамгаалахын төлөөх тэмцэл ч өрнөөд амжсан. Гэхдээ АНУ, ОХУ гэх мэт дэлхийн томоохон гүрнүүд гараа дүрсэн Сирийн дайн намжих найдвар харагдахгүй л байна.

ДУУЛГАХ СОНИН

## Ч.Содтуяагийн бяцхан мисс дэлхийд тэргүүлэв



Дэлхийн бяцхан миссийн тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох охид тодорч эхэлсэн тухай өмнө нь мэдээлж байсан билээ. Тэгвэл энэ жилийн “Дэлхийн бяцхан мисс”-ийн тэмцээн БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагджээ. “Wonder baby international-2016” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцсон охид маань тун ч амжилттай оролцож, тэргүүн байрыг хүртээд иржээ. Мисс ээжийн охин С.Содонгоо реклам сурталчилгаанд тоглож, бүр өөрийн гэсэн дууны клипээ олон нийтэд хүргээд байгаа. Тэгвэл бяцхан загвар өмсөгч маань “Wonder baby international-2016” тэмцээний тэргүүн байрын шагналыг нь хүртсэн байна. Тэрбээр олон улсын хүүхдийн хувцас загварын шоунд оролцох томоохон шалгаруулалтад тэнцэж, “Азийн модель” агентлагаа төлөөлөн явсан С.Содонгоо ийнхүү ээжийнхээ итгэл найдварыг алдсангүй. Энэ талаар мисс Ч.Содтуяа “International kids model contest “Wonder Baby” тэмцээнд түрүүлцгээсэн “Азийн модель” агентлагийн моделиуд болох Содонгоо, Сэлэнгээ хоёртоо зөндөө их баярлалаа. Олон улсын тайзан дээр Монгол Улсынхаа, агентлагийнхаа нэрийг нэр төртэйгээр гаргалаа, баярлалаа” хэмээжээ.

СОНИРХУУЛАХАД

## “Над руу битгий ингэж хар” киног үнэгүй гаргана

Герман улсад ажиллаж, амьдардаг монгол найруулагч Б.Үйзэнмаа “Над руу битгий ингэж хар” киногоороо Олон улсын кино наадмуудад амжилттай оролцсон билээ. Тэгвэл тэрбээр эх орондоо ирж, кино театруудаа киногоо гаргаж байгаа юм. Тэгвэл лесби эмэгтэйчүүдийн тухай өгүүлэх энэхүү киног Монголын ЛГБТ төвөөс дөрөв дэх удаагаа зохион байгуулж буй Тэгш эрх, бахархлын өдрүүдийн хүрээнд үнэ төлбөргүй гаргахаар болжээ. Хэрэв та энэхүү киног үнэ төлбөргүй үзэхийг хүсвэл ирэх бямба гарагт Энхтайван найрамдлын орныг зориорой. Энэхүү киног үнэгүй гаргасны дараа найруулагч Б.Үйзэнмаа үзэгчидтэй уулзалт ярилцлага хийх юм байна.

ТЭНГИС КИНОТЕАТР






Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ

Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиллагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онц ноцтой гэмт хэрэгтнүүдэд өршөөл үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.

